



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-43

<i>1.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/</i>	6-42
<i>2.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/</i>	42-43

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
10 дугаар сарын 24-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл***

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 40 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Ж.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун, Ц.Туваан, Т.Энхтүвшин;
Чөлөөтэй: О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: Г.Дамдинням, Ц.Идэрбат.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын менежер Ц.Хосжаргал, П.Чанцалдулам, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Аудитын менежер Х.Баярмаа, Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Аудитын удирдлагын менежер Л.Мөнхцацрал, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, мөн хэлтсийн мэргэжилтэн С.Гэлэгжунай, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн ахлах шинжээч Д.Отгонжаргал, Н.Уранцэцэг, ахлах мэргэжилтэн Б.Дэнсмаа, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга О.Цогтгэрэл, мөн яамны Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн газрын дарга Ш.Цэрэндулам, Хүрээлэн

буй орчны бодлого зохицуулалтын газрын дарга Б.Буяннэмэх, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газрын дарга Н.Баатарцогт, Аялал жуулчлалын бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Баттөр, Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга Г.Энхмөнх, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батбаяр, Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Оюунжаргал, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын албаны дарга Х.Энхбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Идэрцогт, Салбарын хяналтын газрын дарга Б.Санчиндорж, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт С.Төрмөнх, Ч.Сарантуяа нар байлцав.

Төсвийн төслийн талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Н.Наранбаатар, Г.Ганболд, Ж.Батжаргал, Н.Ганибал, Б.Бейсен, Г.Мөнхцэцэг, Б.Саранчимэг нарын тавьсан асуултад Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулав.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазарын гаргасан, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын VI.1.8.Аялал жуулчлалын байгалийн түүх соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг төсөвт өртөг 2,325.0 сая төгрөг гэснийг тус тус 374.1 сая төгрөгөөр бууруулж, Аялал жуулчлалын байгалийн түүх соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг Булган аймаг, Рашаант сум, Элсэн тасархай төсөвт өртөг 374.1 сая төгрөг 2024 онд санхүүжих дүн 374.1 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээ шинээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 7

Бүгд: 10
30.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазарын гаргасан, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын VI.I.8.Аялал жуулчлалын байгалийн түүх соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг төсөвт өртөг 2,325.0 сая төгрөг гэснийг тус тус 374.1 сая төгрөгөөр бууруулж, Аялал жуулчлалын байгалийн түүх соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг Булган аймаг, Рашаант сум, Элсэн тасархай төсөвт өртөг 374.1 сая төгрөг 2024 онд санхүүжих дүн 374.1 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээ шинээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга Б.Баасандорж, мөн газрын Хууль, эрх зүйн газрын референт О.Дөлгөөнтуул, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, Хууль, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Д.Энхтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

2.Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

3.Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Хуулийн төслүүдийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 24 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 18 цаг 04 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.САРАНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Үндсэн
хууль” танхим 09 цаг 39 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Гишүүд ирээрэй. Хурал эхлэх гэж байна. Ирц бүрдсэн байна уу?

Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Тэгээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52.6 хувьтай болсон учир 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хурал нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулах ёстой та бүхэнд танилцуулъя. Цогт-Очирын Анандбазар Булган аймаг ирсэн байна. Телуханы Аубакир Баян-Өлгий аймаг гадаадад томилолттой, Жадамбын Бат-Эрдэнэ Булган аймаг гадаадад томилолттой, Жигжидийн Батжаргал ирсэн байна Төв аймаг, Буланы Бейсен Баян-Өлгий аймаг ирсэн байна, Хаянгаагийн Болорчулуун гадаадад томилолттой байна, Гочоогийн Ганболд Өвөрхангай аймаг ирсэн байна, Наянтайн Ганибал Сүхбаатар аймаг ирсэн байна, Гонгорын Дамдинням өвчтэй, Цагаанхүүгийн Идэрбат Хэнтий өвчтэй, Гомпилдоогийн Мөнхцэцэг одоо орж ирэх ирнэ, Нанзадын Наранбаатар Өмнөговь аймаг ирсэн, Дамдинсүрэнгийн Өнөрболор Сэлэнгэ аймаг ирсэн, Батсүхийн Саранчимэг Баянзүрх дүүрэг ирсэн, Ганзоригийн Тэмүүлэн Архангай аймаг ирсэн, Цэвэгдоржийн Туваан Орон нутагт ажилтай байна, Одонгийн Цогтгэрэл ирнэ, Цэдэндамбын

Цэрэнпунцаг Завхан аймаг ирсэн байна, Төмөртоогоогийн Энхтүвшин гадаадад томилолттой байна аа.

Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Засгийн газар 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг, санал дүгнэлтийг хэлэлцээд бид нар Төсвийн байнгын хороонд хүргүүлэх учиртай байгаа. Тэгээд энэ 1 дүгээр асуудал байгаа,

Хоёр дахь асуудлаа Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд анхны хэлэлцүүлэг байгаа.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталлаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэхийн өмнө та бүхэнд хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Мөнгөнчимэг Сангийн дэд сайд, Занданбат Монгол улсын ерөнхий аудитор, Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Наранчимэг Аудитын газрын орлогчийн албан үүргийн

түр орлон гүйцэтгэгч, Санхүү-нийцлийн Аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Самбууням Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор, Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Мөнхцацрал Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын аудитын удирдлагын менежер, Баярмаа Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Хосжаргал Санхүү нийцлийн аудитын газрын менежер. Нэрийг нь дуудаж байгаа хүмүүс бас өөрсдийгөө танилцуулахад босоод явчхаарай. Чанцалдулам Санхүү, нийцлийн аудитын газрын менежер, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Сүх-Очир Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Чимидсүрэн Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга.

Байгаль орчин, аялал, жуулчлалын яамнаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Эрдэнэ, Цогтгэрэл Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Цэрэндулам Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Уур амьсгалын өөрчлөлт, бодлогын төлөвлөлтийн газрын дарга, Буяннэмэх Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, бодлого зохицуулалтын газрын дарга, Баатарцогт Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн Бодлого зохицуулалтын газрын дарга, Баттөр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны

аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мөнхтогтох Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Салбарын хяналтын газрын дарга, Энхмөнх Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгалийн нөөц бодлого зохицуулалтын газрын Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга, Оюунсанаа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын дарга, Оюунжаргал Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Цаг уур орчны шинжилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батбаяр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ганбат Байгаль орчин уур амьсгалын сангийн захирал, Энхбат Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын албаны дарга, Дэчин Байгаль орчны яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн гэж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас М.Ганхүлэг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд, Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Идэрцогт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Санчиндорж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газрын дарга, Наранчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Дондогдорж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Довчинсүрэн Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга.

Ажлын хэсгийг та бүхэнд танилцууллаа.

Тэгэхээр Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд Бат-Эрдэнэ танилцуулна. 4 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж, иргэдийн бодит орлогыг хамгаалахад чиглэсэн бодлого арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд улсын эдийн засаг сайжирч улмаар урт хугацааны хөгжлийн эхний 10 жилийн зорилт болох шинэ сэргэлтийн бодлогоо хэрэгдүүлэх боломж бүрдээд байна. Тиймээс шинэ сэргэлтийн бодлогын гол зорилтын нэг болох хот хөдөөгийн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн төсөв, санхүүгийн багц арга хэмжээ хэрэгжүүлэхээр 2024 оны төсвийн төсөлд тусгасан болно оо.

Тухайлбал Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод, хүнсний хангамж, аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, хүнсний ногоо газар тариалангийн ажлын явц, бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг техник технологийн парк, мах, ноос, арьс шир, түүхий эд, хүнс, сүү боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүүгийн

татаасанд зориулж 223.7 тэрбум төгрөг, мөн ойжуулалтын хөтөлбөрийн хүрээнд урсгал зардалд нийт 46 тэрбум төгрөгийг тусгалаа.

Түүнчлэн мал эмнэлэг, газар тариалан, цаг уур, орчны шинжилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох цөлжилттэй тэмцэх зэрэг салбарын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардлагатай зардлыг хянаж тусгасан болно оо.

Шинэ сэргэлтийн бодлогыг дэмжих багц арга хэмжээг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогод 25.3 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага 27.4 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 2.1 их наяд төгрөг буюу ДНБ-ний 2.8 хувь болж төсвийн тусгай шаардлага хангагдаж байгаа болно оо.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, ирэх оны төсвийн төсөлд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр тусгасан арга хэмжээтэй танилцаж Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ сайдад баярлалаа.

Одоо Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат танилцуулна. 2 номерын микрофоныг өгье.

Д.Занданбат: Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллагаас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг 7 зорилтын хүрээнд хянаж, үнэлэхэд аудитын зорилго чиглэсэн. Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг Монгол Улсын Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан дараах шаардлагад нийцсэн гэж дүгнэж байна аа.

1.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсын үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.7 дахь хэсэгт заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна. Засгийн газрын өрийн үлдэгдэл ДНБ-д эзлэх харьцаа 2024 онд 40.7 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв санхүүгийн аюулгүй байдлын бодлогод зохистой харьцаанд байна.

2.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25 их наяд 289.8 тэрбум төгрөг буюу дотоод ДНБ-ний 34.2 хувь, нийт зарлага 27 их наяд 360.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 37 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд 70.8

тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ний 2.8 хувь-ай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ний 2 хувиас илүүгүй алдагдалтай, 19 дүгээр зүйлийн 19.9-д 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй байх. Төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ний өсөлтийн хувь тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс ба баялгийн бус ДНБ-ний өсөлтийн дунджийн аль эхээс хэтрэхгүй байх, Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ний 60 хувиас хэтрэхгүй байх гэсэн төсвийн тусгай шаардлагуудыг хангасан байна.

3.Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг боловсруулахад Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан дараах зорилт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Үүнд:

Шинэ сэргэлтийн бодлогод тусгасан хот хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, экспортыг дэмжих, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг эрчимжүүлэх, иргэдийн орлогыг хамгаалж цалин, тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, хөгжилд суурилсан хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэд эх орондоо оношлогдон эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлэх, уул уурхайн

орлогоос орон нутгийн хөгжлийн санд нэмэлт орлого хуваарилах, иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулах, тогтвортой хариуцлагатай уул уурхайг дэмжиж байгалийн баялгийн үр өгөөжийг орон нутгийн хөгжилд чиглүүлэх, Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдлаар төлөвлөжээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад төвлөрүүлэх орлогын 1.5 тэрбум, зардлыг 226.6 тэрбум төгрөгөөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад төвлөрүүлэх орлогыг 54.5 тэрбум, зардлыг 528.5 тэрбум төгрөгөөр төсөвлөжээ. Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зардлын дүнд 2023 оны тодотгосон төсвөөс 103.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 755.1 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн нь Засгийн газраас 2024 онд нийт албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэх, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих зээлийн хүүгийн татаас үзүүлэх, Төрийн албаны тухай хуулийн дагуу хөдөө орон нутагт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох, Мазаалай баавгайг хамгаалах төвийг шинээр байгуулах, улаан буудай, арьс шир, ноосны урамшууллын зардлын хэмжээ нь нэмэгдүүлэн төлөвлөсөн зэрэгтэй холбоотой байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны урсгал зардлын төсөвт төсвийн хязгаарыг хэтрүүлэн төлөвлөсөн нь 45.1 тэрбум төгрөгийн зардлыг бууруулах боломжтой байна аа.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр нь Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго, зорилттой нийцэж буй хэдий ч Монгол

Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээнээс Байгаль орчин, аялал жуулчлалын яам 2, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дараах 6 арга хэмжээг тусгаагүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэл үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх, Онги-Цагаан бургастайн төслийг эхлүүлэх, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам Монгол Улсыг үхрийн цээж, ямааны годрон, үхрийн тархи сархиагтах өвчингүй тайван байдлыг дэлхийн мал эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагаар баталгаажуулах, мал эмнэлгийн оношилгооны лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хүнсний үйлдвэрлэлийн дэмжлэгийг эцсийн үр дүнд чиглүүлж оновчтой болгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн механизм хэрэгжүүлэх. Нэмэгдсэн өртгийн албан татварын системд тулгуурлан хүнсний бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлыг хянах, бүртгэх, дэмжлэгийг оновчтой болгох, цахим системийг хөгжүүлэх зэргийг тусгаагүй байна аа.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны төсвийн багцад нийт 124.3 тэрбум төгрөгийн 70 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 80.2 тэрбум төгрөгийн 55 төсөл арга хэмжээ тусгагдсан 44 тэрбум төгрөгийн 15 төсөл арга хэмжээ тусгаадаагүй байна аа. Үр дүнд чиглэсэн төлөвлөлтийн аргыг улсын болон орон нутаг мөн салбарын төсөвлөлтөд хэрэгжүүлэх эснээс бий болох үр өгөөж, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор хэмжих үзүүлэлтийг тодорхой болгож хүрэх үр дүнг богино, дунд хугацаагаар

тодорхойлж үйл ажиллагааг хэмжэсэнээр төсвийн зардлын ашиглалт, үр өгөөж нэмэгдэж, төсөвлөсөн хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх боломжтой болно оо.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд хийсэн аудитын дараах дүгнэлтийг танилцуулъя.

1.Төсвийн төсөлд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, татварын орлого зэргийг өөдрөгөөр төсөөлсөн нь төсвийн гүйцэтгэлд эрсдэл үүсвэл төсөвт тодотгол хийх нөхцөлд хүргэж болзошгүй байна.

2.Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа хөтөлбөр бүрийн өртгийг тооцоогүй, арга хэмжээний хүрэх түвшин шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүйгээс төсвийн зорилго хангагдах эсэхийг үнэлэх боломжгүй байна.

3.Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний саналыг эрэмбэлэх, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан эдийн засгийн бодит үр, үр өгөөжийн тооцоо, судалгаа хийх аргачлалыг боловсруулан баталж, Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.11 дэх заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.Гадаад өрийн төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах зорилгоор дотоод үнэт цаас гарган төсвийн алдагдлын тодорхой эх үүсвэрийг бүрдүүлэхээр төсвийн төслийг боловсруулсан боловч түүний үр ашгийг нарийвчлан тооцоолоогүй байна.

5.Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга

хэмжээний барилга байгууламжийн ангилалд магадлал хийгдэж байгаа, 21, нэг маягаар болон жишиг магадлалтай 153 төсөл арга хэмжээг тус тус тусгасан байна.

6.Барилга байгууламжид зураг төсөл, магадлал хийх, худалдан авах ажиллагаа зохион байгуулах, гэрээ байгуулах захиалагчийн хяналт болон гэрээний хэрэгжилтийг хангуулах, улсын комисс, барилга байгууламжийг хүлээн авах зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулан субьектив сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүйн тодорхой нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд дараах асуудлыг толилуулж байна аа.

Төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт тусгуулахад анхаарах, Монгол Улсын Засгийн газар дараа оны төсвийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барихдаа төрийн аудитын байгууллагаас өгч буй дараах зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Үүнд:

Монгол Улсын төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн барихдаа төсвийн төсөл боловсруулах тухайн үе дэх хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэсэн байх. Улсын хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн төсвийн төсөвлөлтийн, шаардлага хангасан төсөл арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх, Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл арга хэмжээний төсөвт өртгийн дүнд өөрчлөлт орж буй

шалтгаан нөхцөлд нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээг авч ажиллах, барилга байгууламжид зураг төсөл магадлал хийх ажлыг зохион байгуулах, худалдан авах ажиллагаа, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх, улсын комисс хүлээн авах үйл ажиллагаанд субъектив сөрөг нөлөөлөлгүй байлгах тодорхой нарийвчилсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгч хэрэгжилтэд хяналт тавих. Хөгжлийн бодлогод нийцүүлсэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүрэн хэрэгжүүлж, салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж чадавхыг нь сайжруулах зэрэг болно оо.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Саранчимэг: Монгол улсын ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат даргад баярлалаа.

Та бүхэнд Монгол Улсын энэ 2024 оны төсвийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн хүргүүлсэнд хүргүүлсэн байгаа.

Тэгэхээр хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүн нэрсээ өгнө үү?

Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа
Өнөрболор гишүүн асуултаа асууя.

Д.Өнөрболор: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Энэ орж ирсэн төсвөөс харахад ер нь энэ нэг жилийн зорилтыг хангахгүй 8 сарын магадгүй түүнээс ч бага настай ийм төсөв орж ирж байгааг ер нь эдийн засагчид судлаачид бол нэлээн их шүүмжилсэн. Би бас тодорхой хэсэг дээр нь бол санал нэг байна гэж үзэж байгаа юм аа. Энэ төсвийн зардал ер нь өссөн хэвээрээ байх юм байна. Инфляц ерөөсөө буурахгүй юм байна. Төр хувийн хэвшилтэйгээ өрсөлддөг байдал бол цаашидаа үргэлжлэх юм байна. Үндсэндээ хувийн хэвшил энэ баялаг бүтээгчдэд бол маш ээлгүй ийм төсөв орж ирж байна гэж бол миний хувьд бас харж байгаа юм. Тэгээд өнөөдөр зөвхөн 2 дугаар улирлын байдлаар л аваад үзэхэд энэ үйл ажиллагаа нь бүрэн зогссон аж ахуйн нэгж нь 45.6 хувиар өсөж 3900-д хүрчээ. Энэнээс худалдааны салбар хамгийн ихээр өртөж байна. 626 аж ахуйн нэгжийг энэ зах зээлээс шахагдаж өнөөдөр хаалгаа барьсан байна.

Тэгэхлээр үндсэндээ энэ Сангийн яам татвараа нэмэгдүүлэхгүй гэж байгаа боловчиг энэ татварын орлогоо өндөр тооцож байгаа нь бол энэ төсөвт өндрөөр тооцож ингэж төсөөлж байгаа нь хувийн хэвшилд бол маш их ийм дарамт болох юм байна. Татварыг хэн бий болгодог вэ гээд тэгэхлээр энэ ажил олгогч нар бий болдог. Хувийн хэвшлийнхэн бүрдүүлдэг. Тэгэхлээр энэ хувийн хэшилээ аргамжчихаад мөнгө ол оо гээд ингээд ташуурддаг байж бол бас таарахгүй гэж бодож байна аа.

Дараагийн нэг асуудал бол ер нь аль ч улс орнууд энэ хүн амаа хүнсээр хангадаг стратегийн салбараа бол байнга дэмжиж хөнгөлөлт үзүүлж, татааж үзүүлж тийм ээ ингээд төрөл бүрээр хөрсөө хамгаалдаг, бордоожуулдаг үйлдвэрлэжүүлдэг, экспортолжуулдаг.

Тэгээд энэ цогц бодлогыг ингээд хэрэгжүүлдэг байгаа. Гэтэл манайд л ингээд Сангийн яам сүүлийн 3 жил энэ өнгөрсөн хугацаанд Хөдөө аж ахуйн яамны салбарын хөрөнгө оруулалтыг бол 70 орчим хувиар Сангийн яам бол дандаа танаж ирсэн. Ийм аудитын тооцоолол байдаг. Энэ жил бол бүүр аймшигтай нь 77 хувь хасагдаж орж ирж байгаа байхгүй юу. 400 орчим тэрбум төгрөгийн саналыг бодлогын яам нь санал болгоход 94 тэрбум л ингээд туссан байж байх жишээний. Төсвийн хөрөнгө оруулалт тэгээд нөгөө хүнсний хувьсгал нь яаж хэрэгжих юм. Энэ дээр би тодорхой хариулт авмаар байна аа. Сая аудитор, Ерөнхий аудитор бас энэ тайлангаа бас танилцуулж байна.

Сангийн яам ингээд маш их ингээд л тооцоолол хийгээд л маш их эд эдийн засгийн эрэмбэ дарааллаар нь ингээд л юмнуудаа жагсаагаад л, нийгмийн ач холбогдлоор нь ингээд аваад үздэг юм уу гээд тэгэхлээр бол энэ аудитын тайлангаас аваад үзэхлээр бас тийм биш байгаа юм. Энэ эдийн засгийн үр ашиг нийгмийн ач холбогдлын тооцооллыг хийгээгүй 295 төсөл хөтөлбөр байж байна гээд тэгж байгаа юм. Ашиглалтын тооцоолол хийгээгүй 286 төсөл арга хэмжээнүүдийг энэ төсөвт тусгасан байна гэж. Тэгээд энэ ажлууд чинь төсвийн хуулийн шаардлага хангаж байгаа юм уу? Тэгээд ийм эрэмбэ дараалалгүй, эдийн засгийн ач холбогдолгүй ийм төслүүдээ ер нь болиод нэн ялангуяа энэ хүн амынхаа хүнсний хэрэгцээ, улс орны тэр байтугай тусгаар тогтнол, аюулгүй байдалтай холбоотой асуудал шүү дээ. Энэ хүнсний асуудал гэдэг бол. Энэ төсөл хөтөлбөрүүдээ одоо хэрэгжүүлэх хэрэгтэй байна аа.

Нөгөөтээгүүр энэ ашиглалтын тооцоолол хийгээгүй байгаа арга хэмжээ туссан байгаад бас би ингээд гайхаад ойлгохгүй л байгаад байна л даа. Энэ 2024, 2025 оны төсөв төсвийн төсөөллийн энэ тооцооллууд дээр ер нь үндэслэлгүй гэсэн үг юм уу, эсвэл энэ зардлын тооцоолол

дээрээ нэмэгдээд ер нь дахиад ер нь яваандаа өөрчилнө өө гэсэн үг юм уу? Энийг нэг л сайн ойлгож өгөхгүй байна. Энэн дээр бас тодорхой.

Б.Саранчимэг: Эхлээд Сангийн яам хариулъя. Хэдэн номер вэ? 7 номерын микрофоныг өгье.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. Бид ирэх 2024 оны төсвийн төлөвлөлтийг хийхдээ макро эдийн засгийн гол үндсэн үзүүлэлтүүдээрээ үндэслэж хийдэг. Бид ямар нэгэн улс төрийн зорилго болон хэт өөдрөг хийсвэр байдлаар төсөөлдөггүй. Бид ирэх онд нийт экспортыг 2023 онд чинь 12.7 тэрбум ам.доллар гэж бид 2024 онд 15.4 тэрбум ам.доллар нийт импортыг бид 9.4 тэрбум энэ оных байгаа. Ирэх жил 10 гээд эдийн засгийн өсөлт энэ 2023 оны батлагдсан 6 хувийн эдийн засгийн өсөлт байгаа энийг бид 7 хувийн өсөлттэйгөөр гарна гэдэг. Ийм байдлаар тооцсон. Гол гол экспортын бүтээгдэхүүнүүдээ дандаа өсөлттэй байдлаар ингэж тооцож байгаа. Энэ 2023 онд төсөв дээр төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл сая Улсын Их Хурлаар 7 сард хийсэн тодотгол дээр бид орлогыг нэмэгдүүлсэн. Үүнтэй холбогдуулан бид цалин, тэтгэврийг бол нэмэгдүүлсэн байгаа.

Тэгэхээр энэ оны төсвийг ер нь төлөвлөхдөө бид тухайн жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл, өмнөх жилийн гүйцэтгэл, тэгээд макро эдийн засгийн төсөөлөл тухайн оны төлөв байдал, гадаад орчны нөлөөлөл, дотоод эдийн засгийн нөхцөл байдалтайгаа уялдуулан ингэж төсвийг тооцож төлөвлөдөг. Тэгээд мөн түүнчлэн эхний хагас жилийн байдал энэ 2023 оны эхний хагас жилийн байдлаар татварын тайлангаа өгсөн аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг нь дүгнэлт хийгээд үзэх юм бол аж ахуйн нэгжүүдийн тоо 7 мянгаар үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн тоо 7 мянгаар нэмэгдсэн. Ийм үр дүнтэй байна. Нөгөө талдаа бид

нар Сангийн яамнаас хөдөө аж ахуйн салбар дээр онцгой анхаарч байгаа.

Хөдөө аж ахуйн салбар дээр энэ онд нийтдээ бид хөрөнгө оруулалтын барилга байгууламж дээр бид 166.1 тэрбум, их засвар дээр 2 тэрбум төгрөг, тоног төхөөрөмж дээр 36.7 тэрбум төгрөгийг тусгаж орж ирсэн байгаа. Энэ нь бол өмнөх жилүүдээс 94.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ийм үр дүнтэй байна. Нөгөө талдаа бид бол Засгийн газраас хэрэгжүүлж байгаа ХАА-н салбарыг дэмжих хүрээнд бид хүүгийн татаас өгөх байдлаар дэмждэг. Энэ дээр ноолуурын бэлтгэл ажлыг хангахад зориулан 4.9 тэрбум төгрөг, 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд малчдад олгох зээлийн хүүгийн зөрөө дээр 1.1 тэрбум төгрөг, хүнсний хангамж аюулгүй байдлыг хангахад зориулж 125.3 тэрбум төгрөгийн хүүгийн татаасыг энэ дээр өгч байгаа.

Үүнд бол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолоор батлагдсан Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөний дагуу 2023 оноос хэрэгжүүлсэн дал гаруй арга хэмжээг санхүүжүүлэх шаардлагатай зээлийн хүүг нь татахад зориулаад зээлдэгч иргэн 6 хувь, аж ахуйн нэгжүүд 5 хувь Засгийн газраас 13 хувийг нь хариуцна гэдэг. Энэнд зориулаад 125.3 тэрбум төгрөг, мөн 10 их наядын цогц арга хэмжээний хүрээнд бид хадгаламжийн нөгөө аж ахуйн нэгжүүдийн зээл авч байгаад Хадгаламжийн даатгалын корпорацыг зээлийн батлан даалтын сангаар дамжуулан өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зориулалт 5 тэрбум төгрөг нийтдээ 136.3 тэрбум төгрөгийг бид 2024 онд тусгаж орж ирсэн.

Нөгөө талдаа энэ 2024 оны төсөв бол өмнөх жилүүдээсээ нэг онцлог нь Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүд 21 аймгаар явсан. Тэгээд энэ дээр бол иргэдийн гаргасан саналыг нэг номерт авч үзсэн байгаа. Ер нь бол сая Улсын Их Хурлаар батлагдсан Төсвийн

хуулиар бол энэ төсвийг Засгийн газраас боловсруулаад иргэдийн саналыг яг авч байхаар ингээд хуульчлагдчихсан. Энийг анхных нь энэ жилийн 2024 оны төсөв болж байгаа. Тэгээд яг иргэдээс авсан саналыг эрэмбэлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг санхүүжүүлэх, ирэх онд хэрэгжүүлэх байдлаар тусгасан байгаа. Мөн адил энэ 2023 оны эхний хагаст аж ахуйн нэгжүүдийн нийт орлого 2023 оны эхний хагас жилийн байдлаар 77.3 их наяд төгрөг хүрч. Энэ өмнөх оны мөн үеэсээ.

Б.Саранчимэг: Аудитын газраас бас нэмж хариулъя. Нэг номерын микрофоныг өгье.

Д.Энхболд: Өнөрболор гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирлын Энхболд.

Төсвийн төсөл дээр энэ жил шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 358 нь шинээр баригдах барилга байгууламжийн төсөл байгаа. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл арга хэмжээг эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий байдлаар нь эрэмбэлэх шаардлагатай. Ашиглалтын зардлыг бол тооцооллыг хийсэн байх гэдэг ийм шаардлага тавьдаг. Энэ шаардлагын дагуу аудитын байгууллага энд 358 төсөл арга хэмжээг бол үнэлж үзэхэд 295 төсөл арга хэмжээн дээр бол эдийн засаг нийгмийн ач холбогдлын тооцооллыг хэлбэр төдий ерөнхий байдлаар хийсэн. Ашиглалтын тооцооллыг мөн 286 төсөл арга хэмжээн дээр хэлбэр төдий хийсэн байсан учраас бид нар энэ тооцооллыг нарийвчлан хийх шаардлагатай гэдэг албан шаардлагыг бол төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгсөн байгаа.

Б.Саранчимэг: Хүнс, хөдөө аж ахуйнаас нэмж хариулъя.

Яг ямар бодлоготой байгаа вэ гээд тэрэн дээр бас нэг асуусан байгаа. Тэрэн дээр нэг нэмээд хариулаадах уу? Хэдэн номер вэ? 6 номер уу? 6 номерын микрофоныг өгье.

Ц.Болорчулуун: Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Өнөрболор гишүүний асуултад нэмэлт хариулт өгье өө. Тэгээд сүүлийн 2 жил бас энэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хангамж, аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөн Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолтой холбоотойгоор салбарын яамны төсөв бас нэмэгдэж байгаа. Тэгээд өнгөрсөн жил гэх юм бол тухайлбал энэ хүүгийн татаас хэлбэрээр 135.5 тэрбум төгрөгийн татаас тэгээд тавьж өгсөн. Үүгээрээ бид бас арилжааны 10 багтай хамтарч 980 гаруй тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийг гаргаад өнөөдрийн байдлаар гүйцэтгэл 60 орчим хувьтай ингээд явж байгаа. Энэ 2024 оны төсөв дээр бас энэ хүүгийн татаас үргэлжилж явж байгаа.

Тийм учраас бол энэ арга хэмжээг үргэлжлүүлээд явахад бид нар хүнсний 36 дугаар тогтоолоор дэвшүүлсэн энэ гол нэрийн 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангана гэдэг энэ зорилт руугаа нэлээд бас дөхөх ийм боломж байна гэж харж байгаа. Мэдээж одоо зээл олголтыг хараад үзэхэд томоохон энэ зоорь, агуулахын аж ахуй, хүлэмжийн аж ахуй дээр бол төдийлөн энэ аж ахуйн нэгжүүд бас банкны шаардлага хангаж явахгүй байгаа.

Тийм учраас энийг бол бас тусдаа арга хэмжээ болгож томоохон аж ахуйн нэгжүүдийн түвшинд зохион байгуулах нь зүйтэй гэж ингэж харж байгаа.

Б.Саранчимэг: Өнөрболор гишүүн тодруулъя.

Д.Өнөрболор: Би Сангийн яамны Ганбат даргаас бас яг тодорхой бөгөөд маш тодорхой хариулт хүсээд байгаа юм л даа. Ер нь энэ жилийн яг энэ төсөв дээр үндсэндээ энэ хувийн хэвшилээ нэлээн их ийм боомилсон өнөөдөр хувийн хэвшилд бол маш ийм ээлгүй ийм төсөв бол орж ирж байна гэдэг нь аягүй ойлгомжтой байна шүү дээ. Та нар хэрэв ингээд энэ хүнд нөхцөл байдалд энэ орлогын энэ татварын орлого чинь тийм ээ ингээд бүрэн бүрдэхгүй байгаа тохиолдолд асуудлаа яах вэ? Энэ өндөр зардлыг. Тэгээд энэ хариуцлагыг нь ер нь хэн үүрдэг юм бэ? Тэгээд ер нь улс орон чинь ингээд ер нь Ерөнхий сайд ч гэсэн бас энэ бүлэг дээр хувийн хэвшлийг дэмжих бас ийм хүсэлт бас тавьж байсан. Тэгээд яг энэ Сангийн яамны оруулж ирж байгаа энэ төсвийг ингээд харахлаар чинь үндсэндээ маш эсрэг ийм байр суурьтай ийм төлөвлөлтүүд орж ирээд байх юм.

Б.Саранчимэг: 7 номерын микрофоныг өгье.

Ж.Ганбат: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Бид бол эдийн засгийн өсөлт саяын миний эхэндээ хэлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дээрээ гадаад, дотоод орчны нөлөөлөл, эрсдэл бүх юмаа тооцоод л ингээд тавьж байгаа. Бид ямар нэгэн хувийн хэвшлийг боомилох тийм бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй ээ гэдгийг би энд хариуцлагатайгаар бол хэлэх нь зүйтэй гэж бодож байна. Засгийн газраас барьж байгаа бодлого бол хувийн хэвшлийг дэмжих аль болох бид хувийн хэвшилд таатай дэмжсэн ийм бодлого явуулахын төлөө байгаа. Бид энэ төсвийн төлөвлөлтөөрөө дамжуулан бид ямар нэгэн байдлаар хувийн хэвшлийг энэ орлогоо нэмэгдүүлсэн байдлаар бид энийг механикаар та нар төлөх ёстой гэж хувийн хэвшилд тулгадаггүй шүү дээ.

Хувийн эдийн засгийн өсөлттэйгөө дамжуулан дотоодын эдийн засгийн өсөлт энэ бүгдийнхээ хүрээнд л бид

хуулийнхаа дагуу л хураах ёстой татваруудаа л хураагаад л явж байгаа.

Тэрнээс биш ямар нэгэн боомилсон хувийн хэвилийг дэмжихгүй бодлого явуулаагүй гэдгийг энэ дээр би хариуцлагатай хэлэх нь зөв гэж үзэж байна. Ер нь бол бид жил болгон төсвийг энэ төсөв бид төсөөлөл төлөвлөлтөөрөө үндэслэж байгаа шүү дээ. Яах вэ мэдээж.

Б.Саранчимэг: 7 номер нэмж хариулъя.

Ж.Ганбат: Бид яах вэ? Аль болох эрсдэлийг тооцдог. Сангийн яам ялангуяа бид хэт өөдрөгөөр төсөөлөхөөс аль болох зайлсхийдэг. Бид хэт өөдрөгөөр төсөөлж байсан өмнөх жилүүдийн туршигууд энэ тэр бол байгаа. 2012-2016 онд энэ тэр бол бас төсвийн бас хэт өөдрөг төлөвлөлтөөс болоод хүндэрч байсан тохиолдлууд байдаг. Бид 2008 оны хямралыг давж байсан. 2012-2016 оны хямралыг давж байсан. Сая 2016-2017 оны хямралыг бид даваад гарч байсан. Бид энэ бүгдийгээ тооцож байж л аль болох хөөстэй өөдрөг төсөвлөж бас эдийн засгаа бид ингээд унагахгүйн төлөө энэ бодлогыг хатуу хэрэгжүүлдэг. Бид хэрвээ энэ дээр ямар нэгэн эрсдэл учрах юм бол бид төсвийн байгууллагуудынхаа аль болох бид нар зардлуудыг эрэмбэлээд явчихдаг. Ийм ийм байдлаар зохион байгуулалттай арга авдаг учраас бид ямар нэгэн хувийн хэвшил дээр аль болох дарамтгүйгээр энэ бүгдийг зохион байгуулаад аваад явдаг гэдгийг танд хариуцлагатайгаар хэлж байна аа.

Б.Саранчимэг: Наранбаатар гишүүн асуултаа асууя.

Н.Наранбаатар: Өнгөрсөн жил бас Монгол Улсын ерөнхий сайд Өмнөговь аймагт очиж ажилласан. Тэгээд хөрөнгө оруулалтуудыг бас иргэдээр эрэмбэлүүлээд ингээд тодорхой ажлуудыг төсөвт тусгаад явж байгаа юм. Тэгээд энэ дээр иргэдтэй уулзаж байхад бас нэлээд дээгүүр эрэмбэлэгдсэн

нэг ажил бол энэ гадаргын усыг говь руу татах төсөл Хөх морь гээд төсөл байгаа юм. Тэгээд энэ төсөв 2024 оны төсвийн төслийг харж байхад бол энэ төсөл дээр ямар нэгэн төсөв хөрөнгө тавигдсан юм харагдахгүй байгаа юм.

Тийм учраас Байгаль орчны яам цаашидаа энэ шинэ сэргэлтийн бодлогод орчихсон энэ томоохон төслийг цааш нь яаж үргэлжлүүлж гэж төлөвлөж байгаа юм. Ямар нэгэн төсөв хөрөнгө тавигдсан зүйл байна уу. Ер нь ТЭЗҮ, зураг төсвийн ажил хийгдэж ТЭЗҮ дууссан. Зураг төсвийн ажил нь дууссан юм уу үгүй юм уу? Хэдий хэмжээний төсөв хөрөнгө шаардлагатай болоод байгаа юм. Яаж энэ төслийг цааш нь явуулъя гэдэг ийм төлөвлөгөө байна вэ гэсэн нэг асуулт байна.

Дараагийн нэг асуулт бол энэ бүтээн байгуулалттай холбоотой бас сөрөг нөлөөллүүд гарч байна. Тухайлах юм бол энэ төмөр замын бүтээн байгуулалт Тавантолгой-Зүүнбаянгийн 414 км төмөр замыг дагасан хориг хашаа тор байхгүйгээс ан амьтан, малчдын мал, ялангуяа энэ бод мал тэмээ дайруулах асуудал ер нь байнга гарч байна. Сүүлийн үед иргэдээс малчдаас маш их саналууд ирж байна. Өнгөрсөн жилээс миний бие бас холбогдох газрууд Зам, тээврийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд өчнөөн бичиг тоотоор ч хэлж байсан. Тэгээд өнгөрсөн жил нэг ажлын хэсэг 2 яамны хамтарсан ажлын хэсэг гараад судалж үзээд тодорхой үүрэг чиглэл санал боловсруулна гэж ярьж байсан. Тэгээд энэ ажлын хэсэг маань бүтэн жил өнгөрсөн байна. Ямар ажлууд хийсэн юм. Яаж шийдэж байна вэ? Энэ төмөр замын хориг хашаа хийх хөрөнгө төсөв ирэх оны төсөв дээр тавигдаж байна уу? Тавигдаж байгаа бол хэдий хэмжээний төсөв хаанаас ямар эх үүсвэрээр тавигдаж байгаа юм бэ гэсэн нэг ийм асуулт байна.

Дараагийн дугаарт энэ Өмнөговь аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний

төвийн барилгын зураг төсөв хийгдээд сүүлийн 2 жил улсын төсөвт тусгуулахаар саналаа ирүүлээд ингээд явж байгаа. Тэгээд энэ 2024 оных дээр байхгүй байна. Ганц Өвөрхангай аймагт л байна. Тэгэхээр Өмнөговь аймагт бол зайлиггүй барих шаардлагатай гээд зураг төсвийг нь аймгийн төсвөөрөө хийлгээд ингээд явж байгаа юм. Тэгээд энэ хаана хасагдчих вэ энийг нэмж суулгах ийм боломж байна уу? үгүй юү гэсэн ийм зүйлүүд дээр хариулт аваад тэгээд тодруулъя аа.

Б.Саранчимэг: Сангийн яамнаас эхлээд Наранбаатар гишүүний асуултад хариулъя. 7 номероос эхэлж хариулах уу?

Ж.Ганбат: Байгаль орчны яам эхлээд хариулах нь зөв байх аа.

Б.Саранчимэг: За тэгье 4 номер хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Хөх морь төсөл Орхон-Онги-Хэрлэн тооно гээд явж байгаа. Төсөв мөнгөтэй холбоотой асуудлууд тодорхой хэмжээнд яах вэ шийдвэрлэгдээд явах боломж бий гэж харж байгаа. Хэрлэнтооны ТЭЗҮ 2014 оны ТЭЗҮ. Энэ ТЭЗҮ-г шинэчлэхээр Оюу Толгой компани, Рио Тинто компани, Эрдэнэс Оюу Толгой компанитай хамтраад Эрдэнэс Оюу Толгой компани дээрээ 3 сая долларын хөрөнгө оруулалтаар тухайн ТЭЗҮ-г шинэчлэх энэ ажлууд бол сонгон шалгаруулалт зарлагдаад явагдаж байгаа. Гэхдээ Хэрлэн голын гадагшаа урсацтай холбоо бүхий асуудлаас үүдэлтэй хил орчмын хилийн хэлэлцээр, усны хилийн хэлэлцээртэй холбоотой асуудлууд энд хөндөгдөж байгаа. Сая БНХАУ-д Монгол Улсын Ерөнхийлөгч бас айлчилсан. Энэ үеэр БНХАУ-ын холбогдох албаныхантай бас уулзсан. Хэрлэн гол дээрх энэхүү гадагшаа урсацтай хэсэг дээр хориглолтуудыг битгий хийж өгөөч ээ гэдэг асуудлыг бол хөндсөн. 2022 онд

Орхон-Онги-Хэрлэн холбоо бүхий асуудал дээр ОХУ-тай хилийн усны хэлэлцээрийг хийсэн хэлэлцээрт Орхоны асуудлыг оруулсан.

2023 онд болгож хойшлуулсан. 2023 оны усны хэлэлцээр 10 сарын 16, 17, 18-ны өдрүүдэд ОХУ-д явагдсан. Энэ дээр бол Орхон голтой холбоо бүхий асуудлыг хөндөхөөр төлөвлөж байсан боловч 2024 онд эргэж ярилцъя гэдэг ийм шийдвэр бол гарсан байгаа. Тэгээд төсвөөс илүүтэй хилийн усны хэлэлцээртэй холбоо бүхий 2 улстай холбоо бүхий асуудал хөндөгдөж байгаа. Тэгээд энэ дээр бол бид нар аль аль талдаа бас ГХЯ-наас дипломат шугамаар тодорхой хэмжээний зөвлөгөө зөвлөмжүүдийг бол Байгаль орчин, аялал жуулчлалын яам авч усны хэлэлцээрт бол орж байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна. Орхон аймгийн хувьд бол 2020 оны ТЭЗҮ-тэй зураг төсөл дээр 6.8 тэрбум төгрөг шаардлагатай. Тухайн төсвийг бол суулгаагүй. Эхлээд хилийн усны хэлэлцээрийн асуудлаа эцэслэн шийдвэрлэж байж зураг төсөлтэй холбоо бүхий асуудлыг эргэж хөндье өө гэдэг ийм байр суурьтайгаар явж байгаа.

Өмнөговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга бол 1956 оны барилга нэлээн эртний барилга. Одоо бараг энэ 21 аймагт байгаа барилгууд дотроос хамгийн хуучны шахуу, модоор баригдсан, таазнаасаа авхуулаад тодорхой хэмжээний цууралтууд үүсчихсэн ийм барилга. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бид нар тавихаар уул нь санал өгсөн. Тэгээд энэ бол хасагдсан. Цаашидаа бид нар тодорхой хэмжээнд орон нутаг болон бусад хувийн хэвшилтэй хамтарсан хэлбэр дээр ялангуяа уул уурхайн чиглэлийн компаниудтай хамтарсан хэлбэрээр явбал яадаг юм бэ гэдэг ийм арга зам олон улсын байгууллагуудтай хамтарсан байдлаар шийдвэрлэвэл ямар боломжтой вэ гэдэг ийм арга зам хайгаад л ажиллаж байгаа.

Баярлалаа.

Б.Саранчимэг: Төмөр замын асуудлаар хэн хариулах вэ? Хашаа. Хэддүгээр микрофоноор хариулах юм. Төмөр замтай холбоотой Сангийн яам нэмж хариулъя. 7 номер.

Ж.Ганбат: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ тэр ус цаг уурын барилга бол цахим системийн нөгөө төслийг нь Сангийн яам хүлээж авахад тэр систем нь шаардлага хангаагүй буюу 8 сарын 15-нд эцсийн байдлаар яамнаас нь ирээгүй гэдэг үндэслэлээр бол хасагдчихсан байна? Яах вэ албан бичгээр бол ирсэн юм байна. Төсөвт өртөг нь 1.8 тэрбум төгрөг гээд. Ийм байдлаар шаардлага хангаагүй гэдэг үндэслэлээр тэр ус цаг уурын барилга бол хасагдсан юм байна.

Төмөр замын хашааг бол төмөр зам өөрсдөө тэр аюулгүй байдал энэ тэрээ хангаж тэр хашаагаа энэ тэрд өөрсдөө хийх ёстой. Энийг бид улсын төсвөөс санхүүжүүлэхгүй.

Б.Саранчимэг: Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: Бид нарт аудитын дүгнэлт тараасангүй.

Тийм учраас энэ 2 бид манай Байнгын хорооны 2 гол яамны төсөв яаж орж ирснийг мэдэх арга алга. Занданбат даргын яриан дундаас нэг хоёрхон л юм сонслоо.

Аудитын дүгнэлтэд байнга л гардаг зураг төсвийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтуудаа болиоч ээ л гээд байна. Яг энэ 2024 оны энэ орж ирсэн төсвүүд дээр шаардлага хангаагүй ямар ямар объект байна? Энэ 2 салбар дээр.

Хоёрт нь та дүгнэлтдээ 5 төсөл ороогүй байна гэх юм. Аудитын дүгнэлт дээр яг ийм дүгнэлт оруулж болдог юм уу? Энд чинь өчнөөн олон санал байгаа

шүү дээ. Наранбаатарын саяын хэлж байгаа төсөл энэ 2 салбар дээр чинь асар олон төсөл байхад энэ 5-ыг энэ 2 салбарын төсөв дээр оруулаагүй байна гээд. Юу гэнэ ээ Онги Цагаан бургасын төсөл гэнэ үү? 5 төсөлд яагаад энийг аудит онцлов? Аудит яагаад энэ 5-ыг мэдэж байгаа юм? Яагаад дүгнэлтдээ энийг оруулж байгаа юм? Энийгээ нэг тайлбарлаад өгөөч ээ.

Хоёр салбарын төсөв ахиухан байвал бид нарт сайн. Засаг дээрээ сайн ойлголцоод төсөв нь ахиухан нэмэгдээд орж ирж байвал бид нарт хэрэгтэй л байна. Байгаль орчны салбарын хувьд бол өнгөрсөн жилийн төсвөөс 45 хувиар нэмэгдсэн байна гэдгийг би сайн үзүүлэлт гэж ингэж бодож байгаа юм. Тэгэхдээ гол нь Байгаль орчны яаман дээр яг энэ хортон шавжтай холбоотой энэ жил бол асар их энэ хортон шавжтай холбоотой асуудлууд дүүрэн байна аа. Ирэх оны төсөв дээр ер нь энэ хортон шавж устгал дээр ер нь хэдэн төгрөг төсөвлөөд хэдэн га-г одоо энэ хортон шавж устгал хийхээр төлөвлөсөн бэ? Энд манай Өвөрхангайн Зүүнбаян-Улаан, Уянга гээд сумдуудын маш олон газрууд нэрвэгдсэн байна аа. Энэ яг орж байгаа юу гэдгийг асууя.

Хоёрт нь аялал жуулчлалын салбар энэ жил өсөлттэй байгаа. Тэгэхдээ аялал жуулчлалын салбар ер нь бол ингээд нэг салбар дундын уялдаа гэхээсээ илүүтэй яг тухайлсан салбар нь энэ бодлогоо жаахан зангидаад явахгүй бол Соёлын яам нь хийгээд байгаа юм уу, Аялал жуулчлалын яам нь хийгээд байгаа юм уу мэдэгдэхгүй. Энэ жил асар их хэмжээний мөнгө энэ гадна дотнын хүмүүс авчирч янз бүрийн юманд зарцуулсан л даа. Эндээс хараад байх юм бол жсоохон уялдаа холбоо гэж жсоохон багатай байгаа юм. Уг нь Аялал жуулчлалын яаман дээр тийм чиглэлийн төсвөө тавиад тэгээд Аялал жуулчлалын яам өөрийнхөө энэ дотоод эвентүүдтэйгээ уялдуулаад яг тэр цаг хугацаандаа тэр үеэрээ энэ гаднын

хүмүүсээ авчраад явах юм бол илүү үр дүнтэй.

Тэгэхээр энэ чиглэлээр яг танай яаман дээр энэ жил тавигдсан хөрөнгө зардал ер нь хэр их байна вэ гэдгийг асууя.

Хөдөө аж ахуйн яаман дээр энэ вакцины хөрөнгө энд хэчнээн төгрөг тавигдсан бэ? Одоо бид нар яриад байгаа нөгөө бүх малаа нэг зэрэг вакцинжуулъя гээд энд л энэ жил ахиц дэвшил байна уу? Өнгөрсөн жилийн энэ вакцины үр дүн хэр байв. Ирэх онд ер нь хэд орчим хувийг нь вакцинжуулах гэж байгаа вэ. Ирэх оны нөгөө жил болгон хэрүүл хийдэг энэ нэг малчдын энэ нэг урамишууллын юмнуудыг нэг зүгээр хэл амгүй өгчхөж байвал яадаг юм бэ? Ирэх онд хэдэн төгрөг тавигдсан юм. Энэ жилийн мөнгөнүүд нь яг хэзээ өгөгдөх юм. Одоогоороо өгөгдөөгүй тэгээд заавал нэг хэрүүл уруул хийж байж өгдөг нэг энэ нэг юмнаасаа салаад энэ төсөв дээрээ эсвэл би жил болгон л хэлдэг юм, Ганбат дарга аа. Тэр нэг урамишууллын юмнуудыг нь энэ аль багц дээр нь байгаа юм тэр сайдын шууд зарцуулах дээр нь байвал тэрийг ер нь бол жаахан хүснэгтэд оруулж хувааж баталж өгмөөр байна. Ерөнхийд нь биш дараа нь энэ шинэ хөдөө гээд нэг баахан төсөл орж ирэх юм аа. Энэний үр дүн ер нь ямар байгаа юм бэ? Яам одоо жишээлэх юм бол өнгөрсөн жилийн энэ шинэ хөдөө төслийн хүрээнд хэдэн тэрбум төгрөг зарсан юм. Яг юунд зарсан юм та нар очиж үзсэн үү?

2024 онд эргээд энэ 40 тэрбум шахуу төгрөг шинэ хөдөө гээд л байж байх юм. Тэгээд дотор нь одоо Дундговь аймгийн Хулд суманд ноос хяргах төхөөрөмж 469 сая төгрөг гээд байх юм. Нэг суманд 469 сая төгрөгөөр тэгээд малчин болгонд нь хонь хяргах хайч авч өгөх юм уу? Яагаад тэр сумыг ялгаад байгаа юм. Энэ төсөв дээрээ энэ яам.

Б.Саранчимэг: Ганболд гишүүн дахиад нэг минут өгье.

Г.Ганболд: Тэгээд энэ Дархан арьс ширний цогцолбор дээр цэвэрлэх байгууламж 23.8 тэрбум гээд тавьчихсан байна. Энэ яах гэж байгаа юм? Нөгөө өмнө нь хийсэн хувийн хэвшлийнхний оруулсан хөрөнгийг ингээд улсын төсвөөс буцааж өгөх гэж байна уу? Эсвэл одоо энийг мөнгө тавьж тусад нь нөгөө төрийн байгуулсан компани нь дахиад 23.9 тэрбумаар цэвэрлэх байгууламж тусад нь дахиад параллель барих гэж байна уу? Энэ яг ямар шалтгаантай ийм мөнгө тавигдсан юм бэ гэдгийг асууя?

Б.Саранчимэг: Ганболд гишүүн маш тодорхой асуултууд асуусан. Тэгэхээр 2023 онд бас 20 тэрбум гаруй төгрөгийн Шинэ хөдөө төсөлд бас ингэж тавигдсан байгаа. Тэгэхээр энэ хэдэн аймагт яг ямар байгаа гэдгийг бас тодорхой асуулаа шүү дээ. Одоо нэг сумд гэхэд 469 ганц тэр төхөөрөмж гээд. Энэ дээр бас хамгийн эхлээд нөгөө аудитаас эхлээд хариулчихъя. Нэг номерын микрофоныг өгье.

Д.Энхболд: Ганболд гишүүний асуултад хариулъя аа.

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал Энхболд.

Төрийн аудитын байгууллага улсын үндсийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг дүгнэлт гаргахдаа 1 дүгээрт алсын хараа-2050 дунд хугацааны бодлогууд жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг тухайн жилийн төсөвтэй харьцуулан авч үзсэн. Тухайн жилийн төсөв нь тухайн жилийнхээ жилийн хөгжлийн төлөвлөгөөний төсөл арга хэмжээгээ дэмжих ёстой гэдэг энэ зарчмын дагуу авч үзэхэд салбар бүр дээр бид нар Байнгын хороон дээр холбогдох салбаруудын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдээс орхигдсон зүйлсүүдийг бол хэлж байгаа, дурдаж өгч байгаа. Энэ

дээр бол Байгаль орчны яаман дээр 2, Хүнс, хөдөө аж ахуйн яаман дээр 5 арга хэмжээ байгааг аудитын тайланд дурдсан.

Аудитын тайланг 10 сарын 13-нд гаргаад бид нар Төсвийн байнгын хороонд гишүүдийн тоогоор бол хүргүүлсэн байгаа. Тэр дараагийн асуулт нь бол шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ хэд байгаа юм бэ гэдэг дээр аудитын байгууллагад түрүүн 295, 286 төсөл арга хэмжээний эдийн засгийн ач холбогдлыг нарийвчилсан тооцоолол хийгээгүй төсөл арга хэмжээнүүд дээр бол албан шаардлага өгсөн байгаа гэдгийг энэ дээр.

Б.Саранчимэг: Нэг номер дахиад нэмж хариулъя.

Д.Энхболд: Аудитын энэ тайлан дээр ард талд нь 4 хавсралт байгаа. Энэ 4 хавсралт дээр бол яам тус бүрээр нь салбараар нь зураг төсөвгүй, зураг төсвийн шаардлага хангаагүй нэг хэв маягийн магадлалын шатдаа явж байгаа гэсэн асуудлуудыг төсөл арга хэмжээ тус бүрээр нь хавсаргачихсан байгаа. Танд энэ тайланг хүргүүлчихье. Төсөл арга хэмжээ тус бүрээр энэ байх шиг байна. Ийм л юм өгсөн байх шиг байна.

Б.Саранчимэг: Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас нэмж хариулах уу?

Хэдэн номер вэ? Таван номерын микрофоныг өгье.

М.Ганхүлэг: Ганболд гишүүний асуултад хариулъя.

2024 оны улсын төсвийн хувьд хөдөө аж ахуйн салбар дээр бас урамшуулалтай холбогдолтой асуулт асуусан. 2023 онд улаан буудайн урамшуулалд 15.9 тэрбум төгрөг, сүүний урамшуулалд 5.9 тэрбум төгрөг, арьс ширний урамшуулалд 8 тэрбум төгрөг, ноосны урамшуулалд 9.3 тэрбум төгрөг, хүнсний ногооны ур урамшуулалд 6.1 тэрбум төгрөгийн бас урамшууллуудыг

олгосон. Энэ жилийн 2024 оны төсөвт бол хэмжээнд бас урамшууллуудыг нэмэгдүүлэхээр тооцсон байгаа. Хэмжээгээр нь олгохоор тооцсон байгаа. Урамшууллыг үргэлжлүүлээд яг саяын үндсэн агуулгынх нь дагуу оруулахаар тусгасан байгаа гэдгийг бас хэлье. Шинэ хөдөөтэй холбогдолтой 2024 оны төсөв арга хэмжээн дээр нийтдээ 29.6 тэрбум төгрөгийг үндсэндээ санхүүжүүлэхээр тооцсон байгаа. Тодорхой одоо бас аймаг орон нутгуудаас Их Хурлын гишүүд болон бас иргэдийн саналыг үндэслэж энэхүү хөтөлбөрийг зохион байгуулдаг. Яг орон нутаг дээрээ бас хэрэг хэрэгцээтэй байгаа тоног төхөөрөмж хүлэмж яг хөдөө аж ахуйн чиглэлийн бас төслүүд дээрээ бас үр дүнгээ өгөөд явж байгаа ийм төсөл хөтөлбөр бас арга хэмжээ байдаг. Тодорхой одоо бас юу мэргэжлийн Хүнс, хөдөө аж ахуйн яамны зүгээс мэргэжлийн багийн зөвлөгөөнүүдийг орж ажилладаг ажлын хэсгүүдийг байгуулж ажилладаг. Гол одоо худалдан авалтыг төрийн худалдан авах газар зохион байгуулаад Хүнс, хөдөө аж ахуйн яаманд хяналт тавьж мэргэжлийн зөвлөгөө өгөх байдлаар үндсэндээ зохион байгуулаад явдаг байгаа. Энэ жилийн хувьд бол үндсэндээ Шинэ хөдөө төслийг багтаагаад 29.6 тэрбум төгрөгийн бас хөрөнгө оруулалтыг төсөвлөсөн байгаа.

Дархан арьс, ширтэй холбогдолтой асуудал. Өнгөрсөн онд 2023 онд ажлын хэсэг байгуулагдан ажилласан байгаа. Хөгжлийн банк болон Хүнс, хөдөө аж ахуйн яамны хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хамгийн хэд хэдэн тодорхой үр дүнгүүд гарсны нэг нь бол яг одоогийн байгаа хувийн хэвшлийн хийсэн бүтээн байгуулалтын энэ төсөл арга хэмжээнийхээ үнийн дүнг тогтоож авсан байгаа. Тэгээд яг одоо батлагдсан байгаа энэ дэд бүтцүүдийг үе шаттайгаар хүлээн авах энэ чиглэлийн ажлууд дээр бэлэн байгаагаа Хүнс, хөдөө аж ахуйн яам илэрхийлсэн. Одоо бол хувийн хэвшил болон Хөгжлийн банк хоорондоо ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу тодорхой хийгдсэн бүтээн

байгуулалтыг шилжүүлэн авах тохиролцох энэ үйл явцууд явагдаж байгаа. Тэгээд үүний хүрээнд бол хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын үйл ажиллагааг 2024 онд дуусгах, тэр дундаа цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг дуусгах чиглэлээр энэхүү төсвийг оруулсан байгаа. Тэгэхээр Хүнс, хөдөө аж ахуйн яамны зүгээс бол Хөгжлийн банк болон хувийн хэвшлийн одоогийн байгаа бүтээн байгуулалтыг 1 дүгээрт үргэлжлүүлэх энэ ажлыг зохион байгуулах чиглэл дээр зөвлөгөө саналуудаа өгөөд ингээд явж явж ажиллаж байна.

Үнэхээрийн энэ ажлын үйл явц шүүхийн хувьд бусад чиглэлээр маргаантай байгаа тохиолдол бид бүхэн 25 га дээрх бас төрийн өмчит компанийнхаа төслийг түр зогсоосон ийм байдалтайгаар бас байлгаж байгаа. Тэгээд аль аль хувилбар байдлаар нь бол үндсэндээ цэвэрлэх байгууламж, 2 бүтээн байгуулалтын ажил дээр нь хоёулан дээр нь үндсэндээ ашиглах бүрэн боломжтой ийм байдлаар тооцсон байгаа гэдгийг хэлье.

Вакцинжуулалтын хувьд Мал эмнэлгийн газраас мэдээлэл өгөх үү?

Говьсүмбэр, Дундговь дээр шинэ хөдөө төслийн хүрээнд 1.5 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байгаа. Тэгээд судалгааны ажил болон аймгийн иргэдийн тэр саналыг үндэслээд тодорхой хэмжээнд Их Хурлын гишүүд Сангийн яаманд уламжлаад л орж ирсэн байгаа.

Б.Саранчимэг: Ганболд гишүүн яг нэг тодорхой асуулт асуугаад байна шүү дээ. 500 саяыг яагаад нэг суман дээр ингээж тавьсан юм бэ гээд. Тэрийг хариул даа.

5 номерын микрофон дахиад нэг минут өгье.

М.Ганхүлэг: Иргэд гишүүдээс одоо бас өгч байгаа санал байгаа юм гишүүн ээ. Тэгээд Сангийн яаман дээр

тодорхой бас ажлууд нь эрэмбэлэгдээд ингээж бас орж ирдэг байгаа.

Б.Саранчимэг: 4 номер нэмж хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Ганболд гишүүний асуултад хариулъя.

Энэ жилийн хувьд бол 2023 онд бас Байнгын хорооны гишүүддээ бид нар дахин баярлалаа гэж хэлэх ёстой. Яагаад гэхлээр өнгөрсөн жилийн төсвийн хэлэлцүүлгийн үеэр ойн хөнөөлт шавжтай тэмцэх асуудал ойн хөнөөлт шавжид нэрвэгдсэн голомтлогдсон талбайтай холбоо бүхий асуудлууд хөндөгдөж байсан. Үүний хүрээнд бас Байнгын хорооноос дэмжсэнээр 8.3 орчим тэрбум төгрөгийг нэмж тавьснаар энэ жил бол энэ ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлууд маш сайн хийгдсэн. Ер нь бол Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хууль хяналтын байгууллагатай хамтарч ажиллаж байгаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гэхээс илүүтэй Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтээр төвлөрсөн мөнгөнөөс ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлууд эргэн зарцуулагдаж байх ёстой. Ялангуяа ойн хувьд бол 85 хувийг, 85-аас доошгүй хувийг эргэн зарцуулах үүрэгтэй.

2023 оны хувьд Өвөрхангай аймаг нийтдээ 73.6 хувийн хэрэгжилттэй байгаа. 2022 оны хувьд, 2021 оны хувьд бол 21 хувийн хэрэгжилттэй байсан. Тэгээд энэ бол бас огцом өсөлт орж ирсэн. Авлигатай тэмцэх газартай Байгаль орчин аялал жуулчлалын яам хамтарч ажилласны үр дүн гарсан болов уу гэж бодож байгаа.

Гуравдугаарт, 2023 оны хувьд бол Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Оюу Толгой, Рио Тинто Монгол ХХК-тай хамтраад бас хувийн хэвшлийн хүрээнд 150 мянган га газар, 2023 онд 150

мянган га газар гээд ингээд 2 жилийн хугацаанд нийтдээ 300 мянган га газар дээр бол ойн хөнөөлт шавжтай тэмцэх энэ ажлыг эхлүүлэх дээр төлөвлөөд гэрээ санамж байгуулагдаад ажил бол хийгдээд явж байна. 2023 оны хувьд микробиологийн аргаар буюу агаарын хөллөг ашиглаад бид нар 120 мянган га талбайд бол хортон шавжтай тэмцэх хор цацах ажлыг бол бид нар хийсэн. Үүргийн шүршигч багаж ашиглаж бид нар 40 мянган га-д хийсэн. Гэрлэн урхи, дэлгэц байрлуулах аргаар бол 5 мянган га гээд. Гэх мэтчилнээр бид нар 2023 оны хувьд бол нийт голомтлогдсон 735 мянган га талбайн 85 мянган га голомтлогдсон талбайд бол яг хүрч очиж бол ажиллаж чадсан.

2024 оны төсөв дээр нийтдээ яг энэ ойжуулалтын хөтөлбөр дээр бол 47 тэрбум орчим төгрөг бол төсөвлөгдөж байгаа. Үүний 22 орчим тэрбум төгрөг нь бол бас энэ ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд зарцуулагдахаар төлөвлөгдөж байгаа. 2023 оны хувьд бол бид нар 236.5 мянган га талбайд бол улсын хөрөнгө оруулалтаар ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажил бол хийгдэнэ ээ гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Өвөрхангай аймгийн хувьд бол 2023 онд Бат-Өлзий, Хархорин, Хужирт сумдуудад ой хөнөөлт шавжтай тэмцэх ажил хийгдсэн. Нарийвчилж үзэх юм бол Бат-Өлзий суманд бол 10 мянган га, Хархорин сумд 4 мянган га, Хужиртад 6 мянган га, 2024 онд Өвөрхангай аймгийн хувьд бол нийтдээ 20 мянган га талбайд ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажил хийгдэхээр төсөвлөгдсөн, төлөвлөгдсөн. Энэ бол Зүүнбаян-Улаан, Уянга, Хайрхандулаан гэсэн 3 сум дээр бол нийтдээ 22 мянган га талбай хамарсан. Ялангуяа энэ 22 мянган га талбай бол голомтлогдсон талбай. Тэгээд энэ судлаачдын манай тандалтын багийнхны явж ирсний дагуу бол энэ 3 сум дээр бол 22 мянган га-д хийх шаардлагатай гэсэн ийм тооцоо мэдээллүүд бол гарсан байна.

Аялал жуулчлалын хувьд Соёлын яамтай бид нар хамтарч ажиллаж байгаа. Төсөв мөнгө бол Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас гарч байгаа. Зөвхөн соёлын яам биш Засгийн газар кабинетын зарчмаар ажиллаж байгаа. Гадаад харилцааны яам... /минут дуусав/.

Б.Саранчимэг: Ганхүлэг сайд нэмж хариулъя гэж байна тэ? Тэгэхээр Ганболд гишүүн их тодорхой асуулт асуусан шүү дээ. Сая яагаад нэг сум дээр очоод Шинэ хөдөө гэдэг төслөөсөө гадна нэг суман дээр ингээд ноос хяргах төхөөрөмж гээд байна аа? Тэрэн дээр бас ер нь энэ шинэ хөдөө төслийн үр дүн энэ дээр ямар нэгэн шинжилгээ, дүн шинжилгээ хийсэн зүйл байгаа юу?

5 номерын микрофоныг өгье.

М.Ганхүлэг: Ганболд гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

Вакцинжуулалттай холбогдолтой асуулт асуусан. 2024 онд малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээтэй холбогдолтой зардлыг 13.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр үндсэндээ тогтсон байгаа. Аудитын дүгнэлт дээр энэ нэгж малын өөрийн өртөгтэй дүйцэхүйц хэмжээтэй байна гэдэг ийм бас мэдээлэл бас гарсан байна лээ. Энэ дээр бас би тодорхой тайлбар өгье өө гэж бодож байна.

Нийтдээ 2024 оны улсын төсөвт 69.8 тэрбум төгрөг төлөвлөсөн. Үүнийгээ 71.1 сая малд тооцохоор нэгж малд нь 982.4 төгрөг болж байгаа юм. Тэгэхээр яг яаж тооцсон бэ гэдэг дээрээ бас аудит дээр бас ингэж хариу тайлбар өгье, нийтдээ энэ жил 52.5 сая тун вакциныг хийхээр тооцсон байгаа. Шүлхийн вакцинд бол 15.1 сая үхэр хамруулахаар, бог малын мялзангийн вакцинд 31.6.

Б.Саранчимэг: Тодруулах уу? Ганболд гишүүн тодруулъя.

Г.Ганболд: Яах вэ ер нь хариултууд авчихлаа даа. Би зүгээр дээр нь нэмээд нэг ганцхан зүйл хэлчихье.

Байгаль орчны сайдад самартай холбоотой. Энэ жил бол бас энэ орон нутагт энэ самар бас гайгүй байгаа юм байна. Энэнтэй холбоотой нөгөө самрын нөгөө үйлдвэрлэлийн зориулалтаар зарим нь юу билээ? Ахуйн зориулалтаар гэдэг билүү? Энийг нэг жоохон ингээд бодит амьдрал дээр тулгуурлаж өгөхгүй бол зарим самар бүхий газруудад үйлдвэрлэлийн зориулалттай зөвшөөрлөө бага олгосонтой холбоотой нөгөө гарал үүслийн бичиг дээр бас нэлээн нугалаа гарч энэ дээр бас нэг авлигал, хээл хахуультай холбоотой. Эсвэл өөр газраас самар авсан хүмүүс нь бусад газруудад мөнгө өгч энэ гарал үүслээ хийлгэж авах дээр нэлээн асуудлууд их үүсэж байна аа.

Тэр дундаа та нар нэг Өвөрхангайн Бат-Өлзий энэ тэрийг нэг эргээж нэг хараадхаарай сайд. Тэгээд энийгээ бол яг тухайн орон нутгийн яг энэ гарч байгаа самар дээр нь уялдуулаад.

Б.Саранчимэг: Санал хэллээ гэж ойлголоо. Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хэд хэдэн асуулт байгаа юм. Мал эрүүлжүүлэлт дээр тодорхой нэмэгдүүлээд хөрөнгийн дүн ярилаа. Тэгээд энүүгээр ер нь хэдий хэмжээний ажил хийгдэх юм бэ гэдэг асуудал байна аа. Бид энэ нэг шүлхий, цэцэг гээд гол юман дээр анхаарал төвлөрчөөд мал эрүүлжүүлэлтийн бусад технологийн цаг хугацаатай ажлууд удаашираад болж өгөхгүй байна аа. Татран халдварт хордлого ч гэдэг юм уу энэ юмнуудын чинь вакцин юмнууд цаг хугацаанаасаа хоцорч ирээд байх юм. Энэ чиглэл дээр ер нь ирэх онд юу хийгдэх юм бэ? Энэ дээр нэг тодорхой хариулт авмаар байна.

Хоёр дахь зүйл, стратегийн болон технологийн нөөц бүрдүүлэлттэй холбоотой 50 орчим тэрбум төгрөгийн асуудал байгаа юм уу гэж харагдаад байгаа юм. Уншаад байхаар. Тэгэхээр энэ одоо ер нь яг хэдэн төгрөг байна. Энүүнийг ер нь ямархуу байдлаар ашиглах юм. Зөвхөн намар ургац авах байдлаар ашиглах гээд байна уу, эс үгүй бол энэ газар тариалангийн үйлдвэрлэлийг удирдах хэлбэрт нь ашиглах юм уу гэж. Хаврын тариалалтад энэний тодорхой хэсгийг гаргадаг эрх зүйн тэр зохицуулалтыг нь хийх тэр бололцоо боломж байгаа юу? Тэгээд гарсан мөнгөө буцаагаад будаа хэлбэрээрээ татаж авдаг. Энэ зохицуулалт хийж чадах уу гэсэн нэг ийм зүйл байна.

Гурав дахь зүйл. Зээлийн хүүгийн зөрөөнд тодорхой мөнгө байна 125 тэрбум ч гэдэг юм уу. Энэний цаад эх үүсвэр банкнаас гарч чадаж байгаа юу? Энэ жил бид нар мөнгөний бодлого ярьж байхад нэг 50 орчим хувь, оны эцэс гэхэд 60 орчим хувийн л эх үүсвэр нь гарах юм байна гэж ингэж яригдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг ер нь яаж зохицуулах юм? Бид хэдийн зориод байгаа зорилт чинь үйлдвэрлэлийн хэмжээгээрээ тавигдчихаад байдаг тэрнийгээ дэмжих хөрөнгийн дэмжлэг буюу хямд эх үүсвэртэй хөрөнгө гаргах гээд хүүгийн зөрөө олгоод байдаг. Гэтэл банкнаас өнөөх чинь гарч өгдөггүй. Энэ асуудал чинь хязгаарлагдчихаад байх юм. Энийгээ яая гэж бодоод байна. Та хэд яаж тооцож байна гэж. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан эргэн төлөлтөөр юм шиг байгаа юм нэг дөчин хэдэн тэрбум төгрөгийн асуудал байгаад байна. Энэ орон нутгуудад яаж хуваарилагдах юм? Эргэн төлөлтөөс гарч байгаа учраас наадах чинь яг өнөө үйлдвэрлэлийн гол идэвхжилийн цаг үетэйгээ давхцахгүй л байна л даа. Төлөгдөж байгаа зээл нь тэр сүүлд төлөгдөөд тэрнийхээ орж ирснээр буцаагаад зээл олгоно гэхээр юм хийж бүтээх гэж байгаа улсаа дэмжих хөрөнгийн эх үүсвэр байхгүй.

Ингээд том дүнгээр нь гэдэг юм уу нэгдсэн байдлаар нь харахаар гайгүй хэдэн төгрөг байгаад байгаа юм шиг хэрнээ яг амьдрал дээр очихоор зэрэг болж өгөхгүй байгаад байгаа юм. Энүүнийг ер нь яаж зохицуулна гэж хараад байна гэж. Түрүүн Ганболд асуучих нь лээ. Тэр энэ түүхий эд боловсруулах чиглэлээр ер нь гадаадын төсөл хөтөлбөрийн зээлийн хөрөнгө дээр ер нь ямар юм байгаад байгаа юм бэ? Тэр Дарханы цогцолборыг яах вэ? Дэд бүтцийг нь бид ингээд нэг янз бүрийн байдлаар хийдэг юм байж. Яг үйлдвэр барих гэдэг юм уу тэр технологи нэвтрүүлэлт гэдэг юм уу энэ юм нь ирэх оны юун дээр ер нь ямар юм байгаад байгаа юм? Тэр гадаадын зээл тусламжийн хөтөлбөр дотор чинь. Энүүнийг нэг тодруулчихмаар байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэд хэдэн асуулт байгаа юм. Энэ цаг уур орчны шинжилгээний төвийнхөө зардал дотор өнөө үүлэнд нөлөөлдөг гэдэг юм уу хур тунадас нэмэгдүүлдэг арга хэмжээнд хэдий хэмжээний хөрөнгө байгаад байгаа юм бэ? Энэ бидэнд ер нь юу юунаас чухал байгаад байгаа шүү. Таримал ч тэр байгалийн ургамалд ч тэр хамгийн гол хэрэгтэй зүйл энд яваад байгаа. Энүүнийг ямархуу байдлаар шийдэх гэж байна вэ?

Улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад үйл ажиллагаа явуулахад нь зориулаад нэг тодорхой зардлууд байгаад байна аа. Гэтэл зардал юмаа өөрөө хариуцаад байгаа тэр олон нийтийн байгууллагууд авч яваад байгаа ганц нэг газар бий. Тэр аж ахуйнууд байгууллагууд дээр ер нь ямархуу хэмжээний дэмжлэг.

Б.Саранчимэг: Эхлээд Хөдөө аж ахуйн яам хариулаад, дараа нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам хариулъя. 5 номерын микрофоныг өгье.

М.Ганхүлэг: Мал эрүүлжүүлэхтэй холбогдолтой асуудал. Манай салбар чухал асуудал байгаа юм. 13.1 тэрбум төгрөгийг дотроо бол нэмэгдүүлж байгаа 2 их гол асуудал байгаа. Нэгт энэ био үйлдвэрлэлийн вакцины бас тодорхой үнэ ханиш нэмэгдсэнтэй холбогдолтой 6.6 тэрбум төгрөгийг энэ дээр тооцсон байгаа. Яг таны саяын асууж байгаа юун дээр нийтдээ нэг 5 сая тун вакциныг энэ жил бид бүхэн бэлтгэж гаргахаар болсон байгаа. Тэгээд хамгийн гол нь энэ мал эрүүлжүүлэх үйл ажиллагааны гол суурь асуудал болсон малын үйлчилгээний хөлсийг бас энэ жилийн төсөв дээр бас нэмэгдүүлэхээр оруулж ирсэн байгаа.

Тэгээд үүн дээр 6.5 тэрбум төгрөгийг бол 2024 онд төсөвлөсөн. Мал юу тарилгын хөлсийг үндсэндээ үхэр дээр бол мянган төгрөг болгох, бог мал дээр бол 350 болгож нэмэгдүүлэхээр тооцсон байгаа. Ингэснээрээ энэ вакцинжуулалтын үйл ажиллагаа хувийн мал эмнэлгүүдийн үйл ажиллагаа нэлээн сайжрах энэ нөхцөл бололцоо бүрдэнэ ээ.

Тэгээд хаа хаанаа бас төсөв зардал нь хүрдэггүй ийм асуудал байдаг. Энэ асуудал бас тодорхой хэмжээнд шийдэгдэнэ.

Хоёрт нь, жижиг, дунд үйлдвэрлэлтэй холбогдолтой асуултыг асуулаа. Үндсэндээ жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн үйл ажиллагаа бол нэлээн нийгэмд ил тод болоод шалгаруулалт болон бусад бүх процессыг бас ил тод байдлаар зохион байгуулаад ингээд явж байгаа. Ирэх оны төсөв дээр бол тэрбум 40 сая төгрөгийг үндсэндээ энэ дээр оруулсан байгаа. Бусад зардлаа өөрийн эх үүсвэрээр жижиг, дунд үйлдвэрлэлийн газар олгоод явна аа. Нийтдээ 2024 онд 83.7 тэрбум төгрөгийг тооцсон. Өөрийн эх үүсвэрээс бол 50 сая. Бусад Олон улсын байгууллага болон хөдөөгийн хөгжүүлэх төсвөөс ингээд нэмэгдүүлээд 83 тэрбум төгрөгийг бол бид бүхэн бас эргэлтэд оруулах энэ боломж нь бүрдэнэ ээ. Жижиг, дунд

үйлдвэрлэлийг дэмжих гол бодлогоо бол бид бүхэн хөдөөгийн хөгжил рүү чиглүүлж байгаа.

2023 оны нийт төсөл хөтөлбөр арга хэмжээний 75 хувийг нь хөдөө орон нутгийн жижиг, дунд бизнесийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан байгаа. Цаашидаа бас энэхүү бодлогоо бас үргэлжлүүлээд ингээд ажиллаад явна.

Дархан арьс ширний цогцолборттой холбогдолтой асуудал дээр Аж үйлдвэрийн паркийн тухай хуулиараа бол төр дэд бүтцийн асуудлыг хариуцах ёстой. Ингээд дэд бүтцийн хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлуудыг хүлээлцэх асуудалтай холбогдолтой энэ ажлын хэсгийн ажлууд нь явагдаад дүгнэлтүүдээ гаргасан. Одоо Хөгжлийн банк болон хувийн хэвшилтэй бас яг тохиролцох энэ процессын ажил дээр бид нар шахалт үзүүлээд энэ дээр нь тодорхой бас асуудлуудаа ярилцаад ажиллаад явж байна. Хэрвээ бусад дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудаас цаг хожих давуу тал байгаад байгаа юм. Эрчим хүч болон цэвэр дулааны энэ дэд бүтцийн ажлууд нь нэлээн 70, 80 хувьдаа хүрчихсэн. Тэгэхээр аль болох энэ байгаа бүтээн байгуулалтыг цааши нь үргэлжлүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах нь маш чухал бас асуудал байгаад байгаа.

Дэд бүтцийн асуудлаа бүрэн шийдсэн тохиолдолд гаднын хөрөнгө оруулалтууд орж ирэх эхний удаагийн хэлэлцээр уулзалтуудыг хүнс Хүнс, хөдөө аж ахуйн яаман дээр хийгдсэн байгаа. Турк, Итали, БНХАУ гээд ингээд хэд хэдэн улсууд бол тухайн дэд бүтцийг ашиглаад үйлдвэр үйл ажиллагаагаа өөрсдийн хөрөнгөөр мөн Монголчуудтай хамтарсан компани байгуулаад ажиллах энэ боломжууд нь байгаа. Энэ жилийн хувьд бол бид бүхэн цэвэрлэх байгууламжийнхаа ажлыг тусгаад ингээд бас тодорхой дэд бүтцийн асуудлуудыг урагшлуулах ийм зорилготойгоор 2024 оны төсвийг

оруулсан байгаа. Зээлтэй холбогдолтой асуудал дээр.

Б.Саранчимэг: 6 номер нэмж хариулъя.

М.Ганхүлэг: Батжаргал гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр өнгөрсөн жил энэ үрийн болон технологийн нөөц бүрдүүлэх гээд 30 тэрбум төгрөг тавьсан. Энүүгээр бид зөвхөн хүнсний улаан буудайн бус үрийн шинэчлэл нэлээн сайн хийсэн гэж үзэж байгаа. Тухайлах юм бол дотоодоос 6.2 тэрбум төгрөгөөр 4.8 мянган тонн үрийн нөөц бүрдүүлсэн. Импортоор 9.7 тэрбум төгрөгөөр 5.6 мянган тонн үрийн нөөц бүрдүүлсэн. Үлдсэнээр нь хүнсний, улаан буудайн нөөцөө бүрдүүлсэн.

2024 оны төсөв дээр бас 30 тэрбум төгрөг явж байгаа. Энэ дээр бас бид нар үрийнхээ шинэчлэлийг хийгээд 10 орчим тэрбум төгрөгт нь үрийн шинэчлэл байх болов уу гэж тооцоолж байгаа. Үлдэгдэл дээр нь хүнсний улаан буудай нөөцөө бүрдүүлье гэж харж байгаа.

Дээрээс нь сүүлийн жилүүдэд бас энэ Монгол төмс хөтөлбөр гээд хэрэгжсэн Швейцарын хөгжлийн агентлагийн хүрээнд. Энэний хүрээнд дотоодын төмсний үйлдвэрлэл хангасан хэдий боловч төмсний үр бас нэлээд хөширөлттэй, жижгэрэлттэй ийм асуудал гарч байгаа учраас энэ төмсний үрэн дээрээ бас жоохон анхаараад өгье гэсэн ийм төлөвлөгөө гаргаад л явж байгаа.

Хүүгийн хөнгөлөлтөөр бид энэ жилийн тухайд гэх юм бол Сангийн яам Монголбанктай хамтраад зээлийн ерөнхий гэрээг байгуулаад арилжааны 10 банкиг татаж оролцуулж гэрээ байгуулсан. Нийт одоо энэ тавигдсан 125.5 тэрбум төгрөгийн хүүгийн татаасаар 982 тэрбум төгрөгийн эх үүсвэр гарах ийм гэрээг байгуулсан. Яг өнөөдрийн байдлаар 1800 орчим аж ахуйн нэгжүүд 527 тэрбум төгрөгийн зээл

гараад ингээд явж байгаа юм. Тэгээд энэ зээлүүдээ дотор нь ингээд ангилаад үзэхээр түрүүний хэлсэнчлэн зоорь агуулах дээр бол дээрээс нь бид нар энэ шинэ төрлийн таримал элсэн чихрийн үйлдвэр тодорхой хэмжээнд хийе гэсэн. Мал аж ахуйн чиглэлийн цэвэр үүлдрийн мах сүүний чиглэлийн үхрийг импортлож оруулж ирэх гээд. Энэ дээр бол зээлүүд харьцангуй их бага гараад байгаа. Тэрнээс яг банкнуудын гаргаж байгаа эх үүсвэр бол гэрээ байгуулсан хэмжээндээ яг хүрэлцээтэй гарахаар байгаа.

Тэгэхээр одоо бол бид нар энэ зээлээ нэлээд гурван ч удаа бас зээл олгож эхэлснээс хойш гурван ч удаа бас гэрээнд нэмэлт, өөрчлөлт орууллаа. Ингээд харж байгаад ирэх жилийнхээ зээлийг анзаарч байгаад яг ямар чиглэлд явж байгаа дээр нь түлхүү олгох вэ гэдэг тал дээрээ анхаарч байгаад нэлээд явуулбал банкны эх үүсвэр бол хүрэлцээтэй байгаа. Зөвхөн нөгөө банкнаас аж аж ахуйн нэгжүүд давж авах асуудал нь бас жоохон төвөгтэй байгаад байгаа учраас ийм зээлийн хүү харьцангуй нэг 60 гаруй хувьтай л өнөөдрийн байдлаар явж байгаа.

Б.Саранчимэг: Баярлалаа. 4
номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Батжаргал
гишүүний асуултад хариулъя.

2022 оноос ялангуяа 4 дүгээр сараас эхлээд бид нар буудаж эхэлсэн. Таны асуусан борооны нуужин зооноттой холбоо бүхий өнгөрсөн жил бол 1.4 тэрбумын төсөвтэй байсан. Энэ жил бол 1.5 тэрбумын төсөвтэй байгаа. Үүгээр бол 800 орчим ширхэг нуужин худалдаж авдаг. Хавар эрт буудсанаар бороошилт үүсгэснээр бол эргээд газрын чийгийг бий болгох эргээд үүлшилт үүсгэх процесс байдаг юм байна лээ. Тэгээд энэ утга агуулгынхаа хүрээнд бол Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас аль болох эрт тодорхой бүс нутгуудад бол ялангуяа хүнстэй холбоо бүхий газар

нутгуудаар бол эртлэн бороо оруулах энэ ажлууд бол 2 жил дэс дараалаад бол амжилттай хийгдсэн.

Хойд мөсөн далайн хайлалттай улбаатай орж ирж байгаа чийгшилийн хэмжээ ихсэж байгаа. Гэхдээ нөгөө талдаа бид нар хуурайшилттай холбоо бүхий асуудлуудыг шийдвэрлэхийн тулд тодорхой хэмжээний бусад улс орнуудын тухайлбал БНХАУ, Тайланд улс гэх мэтчилний улсуудаас бол бид нар хамтын ажиллагааны хүрээнд тодорхой ажлуудыг бас хийгээд явж байгаа. Монгол Улсын газар нутаг хэт хуурайшилттай эрс тэс уур амьсгалтай учраас бас таарахгүй нөхцөл байдалтай зүйлс бас байна.

Үүнтэй холбоотой хариултыг өгье. Ер нь бол бид нарт жилдээ нөөцтэй хэлбэр дээрээ гэж тооцох юм бол 1100-1200 орчим нуужин бол зайлшгүй шаардлагатай байдаг. Одоо бол бас тодорхой хэмжээнд бид нар цаг үеийн нөхцөл байдлыг дүйцүүлж харж тухайн газар орон нутгийн онцлогоос шалтгаантай байдлаар бид нар бас энэхүү үйл ажиллагаа явуулж байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна. Тусгай хамгаалалттай газар нутгууд, ялангуяа таны асуусан менежментээр шилжсэн газруудтай холбоотой асуудал асуулаа гэж би ойлголоо.

Энэ жил Хустайн байгалийн цогцолборт газарт бол бид нар нэг автомашин өгсөн. Өнгөрсөн жил нэг автомашин өгсөн. Аялал жуулчлалын томоохон бүс болгож бид нар олон улсад зарлаж байгаа. Аялал жуулчлалын компаниуд болон мэргэжлийн холбоодтой тухайн бүсээр заавал жуулчдыг жуулчлуулах гэдэг ийм аялал жуулчлалын цэгт оруулж явж байгаа. 2023 онд бол Хомын талыг бид нарт нэмж менежментээр өгсөн. 2023 оны 1 дүгээр сарын 1-ээс Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулж 1 сарын 6-нд хуульд нийцүүлэх хэлбэрээр Тусгай хамгаалалттай газар нутгийн

тухай хуульд тодорхой нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан. Энэ дээр бол 300 төгрөгөөр авдаг байсан тасалбар бол 3 мянган төгрөг болгож сайдын тушаалаар журамлаж баталсан байгаа. Орж байгаа орлогыг тодорхой хэмжээнд менежментийн хэлбэр дээр өөрөө өөрт нь зарцуулах буюу ашигтай менежментээр зарцуулах энэ тогтолцоог бид нар нэвтрүүлэхээр ажиллаж байгаа.

Байгаль хамгаалагч нарын цалин бол 1 сая 750 орчим мянган төгрөгийн хэмжээнд бол дийлэнх нь бол хүрсэн. Тодорхой хэмжээнд удирдах албан тушаал хашиж байгаа байгаль хамгаалагчдын хувьд бол 2 сая төгрөг давсан ийм цалингийн хэмжээтэй байгаа. Олон улсын түвшинд бид нар хамтын ажиллагаа систэришп эгч дүүсийн харилцаа тогтоох хэлбэр дээр ажиллаж байна. Энэ дээр бол хамтын ажиллагааны хүрээний олон ажлууд хийгдэхээр төлөвлөгдөж байгаа.

Дээрээс нь байгаль хамгаалах итгэлцлийн сан байгуулагдах гэж байгаа. Энэ дээр бол санамж бичгийг 2022 онд байгуулсан. 2023 онд Монголын эдийн засгийн форумын үеэр гэрээ байгуулсан. 70 сая ам.долларын төсөв бүхий ийм санг байгуулж тусгай хамгаалалттай газар нутгуудад зарцуулах менежментийн хэлбэрийг илүү нарийвчилж сайн авч явах ийм ажлууд бол хийгдэхээр төлөвлөгдөөд ажиллаад явж байгаа гэдгийг би танд хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Б.Саранчимэг: Баярлалаа. Батжаргал гишүүн тодруулъя гэж байна.

Ж.Батжаргал: Мал эрүүлжүүлэх арга хэмжээний зардал нэмэгдэж байгаа юм. Гэтэл нормативт зардлуудаа нэмчхэж байгаа юм бид. Одоо наадах чинь орон нутгийн төсвөөс бас хөрөнгө гарч дараагийн зэрэглэлийн тэр халдварт өвчнүүдийн эрүүлжүүлэх чиглэлийн арга хэмжээнүүд хийгддэг. Та хэдийн энэ тогтоосон норматив дахиад орон

нутгууд дээр бууна. Тэгэхээр тэр орон нутгийн төсвүүд дээр буух гээд байгаа ачаалал ер нь ямар хэмжээний юм гарч очдог бол гэдэг асуудал.

Хоёрдугаарт тэр гоц халдварт өвчнөөс чинь бусад халдварт өвчнүүдийн эрүүлжүүлэх чиглэлээрх вакцины чинь хомсдол үүсээд болж өгөхгүй байна аа. Энүүнийгээ ер нь яана гэж бодоцгоогоод байгаа улсууд юм бэ? Энэ дээр ер нь ямар бодлогын чиглэл байгаа юм? Аялал жуулчлалын салбар дээр байна шүү дээ та хэд цэвэрлэх байгууламж, зогсоол цогцолбор, түр отоглох энэ тэр гээд нэг хэдэн төгрөг тавьчихжээ. Нийтдээ үндсэндээ 3 орчим тэрбум төгрөг байх шиг байна гэж. Үгүй ээ энүүнийг ер нь яаж хийнэ гэж бодоод байна аа?

Б.Саранчимэг: 4 номер нэмж хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: 2024 оны төсөв дээр 2.3 тэрбум төгрөгөөр 7 газарт отоглох түр отоглох цэг байгуулах ийм үйл ажиллагаа хийгдэхээр явагдаж байгаа. Хувийн хэвшилээр хийх оролдлогуудыг 2022, 2023 онд бид нар хийсэн. Ялангуяа Горхи Тэрэлжийн бүс нутагт бол тодорхой газар нутгуудыг гаргаж өгөөд хувийн хэвшилтэй хамтын ажиллагааны хүрээнд ажиллахаар бол төлөвлөсөн. Хувийн хэвшил бол дийлэнхдээ отоглох цэгээс илүүтэй бааз барих сонирхол асар өндөр байдаг юм байна. Отоглох цэг бол нөгөө майхантай явж байгаа жуулчдад зориулсан ийм цэг. Тэнд бол бид нар тодорхой хэмжээний ариун цэврийн байгууламжийг нь байгуулж өгөх усыг нь татаж өгөх, усыг нь гаргаж өгөх цахилгааныг нь татаж өгөх ийм ажлууд хийгдэхээр бол төлөвлөгдөж байгаа. Отоглох цэг заавал улсын төсвийн хөрөнгөөр байхгүй байж болно. Энийг бид нар цаашидаа байхгүй болгоно гэж тооцож байгаа. Яагаад гэхээр түрүүний хэлсэн Тусгай хамгаалалттай газар нутгийн орж байгаа тасалбараас бүрдсэн орлогоор тодорхой хэмжээний отоглох цэгүүдийг

байгуулах, тусгай хамгаалалтын захиргаадууд өөрсдөө энэ ажлаа хийдэг байх ийм хэлбэр рүү бид нар шилжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа.

Гэхдээ өнөөдрийн түвшин дээр яах вэ Монгол улсад 600 орчим мянган жуулчин ирсэн байна. 1 тэрбум гаран долларын орлогыг бас тодорхой хэмжээнд оруулсан байна. Нэг тусгай хамгаалалттай газар нутаг, тухайлбал Хөвсгөл аймаг гэхэд жилдээ 100 мянган жуулчин очиж дотоод, гадаадын нийлсэн 3 мянгаар тооцоход 300 сая төгрөг. Нэг отоглох цэгийн дундаж гарах зардал 300 сая төгрөг байгаа. Тэгээд энийг бол цаашидаа бид нар менежментийн хэлбэрт шилжүүлээд явна гэдэг ийм зохион байгуулалтын хэлбэр дээр ажиллаж байна. Ялангуяа газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгах, тухайн тусгасны дагуу сонгон шалгаруулалтыг зарлах тэнд отоглох цэгүүдийг менежментээр хэрэгжүүлэх, нисдэг тэрэгний отоглох цэгт жишээлбэл байгуулах ажлууд хийгдээд явж байгаа.

Нийтдээ 33 цэг дээр нисдэг тэрэгний отоглох байгуулагдах ажил хувийн хэвшилтэй хамтын ажиллагаанд хийгдэхээр тендер сонгон шалгаруулалт нь ингээд удахгүй зарлагдах гэж байна. Гэхдээ газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөгөөтэй байх газрыг яам, аймаг, сум, нийслэл, дүүрэг тусгайлан олгодоггүй байх гэдэг энэ зарчим дээр Монгол Улсын Засгийн газар бас бодлого барьж байгаа. Энэ бодлогын хүрээнд бид нар нэгдсэн шийдэл гарсны дараагаар газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг олон нийтэд зарлаж түүний дагуу сонгон шалгаруулалтуудыг зарлаад явна гэдэг ийм төлөвлөгөөгөөр бид нар ажиллаж байгаа. 2024 он гэхэд бол энэ бүх ажил бол цэгцэрнэ ээ гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Баярлалаа.

Б.Саранчимэг: 6 номер хариулъя нэмж.

А.Нарантуяа: Ингээд та бүхний амрыг эрье ээ.

Мал эмнэлгийн Ерөнхий газар, Нарантуяа. Ер нь бол бас Сангийн яамныхандаа бас баярлалаа гэж хэлье. Яагаад гэхээр мал эмнэлгийн ажил үйлчилгээний хөлсийг ингээд аажмаар үе шаттайгаар нэмэгдүүлэх бидний гол зорилго байгаа. Яагаад гэхээр 84.9 сая малыг шүлхий өвчнөөр эрүүлжүүлэх энэ үйл ажиллагааг явуулахын тулд 3 жил дараалан жилд 200 тэрбум төгрөг ер нь хэрэгтэй. Гэтэл бид нарт тийм эдийн засгийн нөөц байхгүй учраас энэ жилийн тухайд мал эмнэлгийн ажил үйлчилгээний зардал 3 эх үүсвэрээс санхүүждэг.

Нэгдүгээрт нь улсын төсөв, орон нутгийн төсөв, иргэн, аж ахуйн нэгж гээд. Тэгээд орон нутгийн төсвийг Сангийн яам маань бас харж үзээд орон нутагт нь 20 хувиар нэмэгдүүлсэн байгаа. Улсын төсөвт болохоор био үйлдвэрийн зарим нэг дотрын халдварт хордлого, цэцэг өвчний вакцины хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор ялангуяа түүнийг вакциныг бэлддэг эх үүсвэр бол манай технологи ийм хуучин технологиор явдаг. Түүнтэй холбоотойгоор 6.6, мал эмнэлгийн ажил үйлчилгээний хөлс буюу нэг хувийн нэгжгийн малын эмчийн үхэрт зарцуулах бог малд зарцуулах үйлчилгээний хөлсийг 13.1 тэрбумаар нэмсэн байгаа. Тэгээд мал эмнэлгийн ерөнхий суурь түвшин бол манай 56.7 байгаа. Тэгээд бас асуудал байгаа.

Яагаад гэхээр Дорнод аймагт гарсан анх удаа гарсан гоц халдварт өвчний нөхөн олговрыг одоо хүртэл 2023 оны нөхөн олговрыг олгоогүй байгаа гэх мэт. Тэгээд Монгол Улсад 3 гоц халдварт өвчин байгаа. Үүнийг гаднаас авч байна вакциныг нь. Нэг өвчнийг бол био үйлдвэр үйлдвэрлэж байгаа учраас үйлдвэрийнх нь вакцины үнийг нэмсэн байгаа. Ерөнхийдөө өнөөдөр бол Монгол Улсад гоц халдварт өвчнөөр тайван байгаа учраас өнөөдрийн байдлаар 57 мянган тонн мах гадаадад гараад дэлхийн 20 гаруй орон руу мал

эмнэлгийн гэрчилгээ гарч байгаа учраас ямар ч байсан бид нарт тодорхой хэмжээний ахиц дэвшил байгаа гэдгийг хэлмээр байна аа.

Баярлалаа.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр нөгөө вакцинжуулалт чинь яг цагтаа хийгээрэй гэдгийг л манай гишүүд их онцолж байгаа шүү дээ. Тийм учраас төсөвтэй болчихсон энийгээ яг цагт нь хийгээрэй гэж хэлье. Батжаргал гишүүн тодруулъя гэж байна.

Ж.Батжаргал: Зээл цаг хугацаандаа гарах бололцоо байна гээд байгаа юм. Үгүй ээ байгаа юм бол тэгээд наад ашиглах ёстой эх үүсвэрээ бүтэн ашиглаач дээ. Яагаад ашиглахгүй 50 хувьтай байгаад байгаа юм. Наад батлан даалтын санд чинь итгэдэг итгэл байхгүй болчихлоо. Тэр батлан даалтын сангийнхаа баталгаанд нь энэ банк санхүүгийн байгууллагуудад нь итгэдэг итгэлийг бид яаж хийх ёстой юм. Энүүнийг энэ манай Хөдөө аж ахуйн яам энэ тэр ер нь юу гэж хараад байна аа? Нэг ийм асуудал байна.

Хоёрдугаарт төр хувийн хэвшлийн түншлэл дээр хийж болдог ажлуудыг эрчимтэйхэн явуулмаар байна. Одоо жишээ нь наад үүлэнд зориудаар нөлөөлдөг энэ үйл ажиллагаанд газар тариалангийн энэ томоохон компаниудын өөрийн хөрөнгө дээр тулгуурлаж нуужин нэмж захиалах бололцоо байгаа юм уу? Тэрнийх нь удирдлагыг нэгдсэн бодлогоор эндээ барих бололцоо байгаа юм уу? Үүнээс чинь хамаараад наад үйлдвэрлэлүүд чинь тодорхой хэмжээний байгалийн гэж хэлж болохоор бэрхшээл гэдэг юм уу сөрөг нөлөөллүүд үүсээд байна.

Б.Саранчимэг: Нэмж хүнс Хүнс, хөдөө аж ахуйн яам хариулъя. 6 номерын микрофоныг өгье.

М.Ганхүлэг: Зээлийн гаралт энэ жилийн тухайд бид одоо эхний жил гарсан. Тэгээд төсөв 2023 онд төсөв батлагдаад зээлийнхээ ерөнхий хэлэлцээрийг хийх гэж Монголбанк, Сангийн яамтай бид хамтарсан хэлэлцээр хийгээд дахиад одоо арилжааны банкнуудтайгаа хэд хэд хэдэн удаагийн уулзалт, хэлэлцээрт хүрээд ер нь эцсийн байдлаар зээл 4 сарын 8-аас яг гарч эхэлсэн. Тэгээд 1 дүгээрт эхний 4 сарыг бол аж ахуйн нэгжүүдийн гар дээр 5 сарын 1-гээд зээлүүд гарсан учраас эхний 4 сарыг бол бас нөгөө алдаж гарсан тал байгаа.

Тийм учраас бас зээлийн гаралт харьцангуй бага гарч байна гэж ингэж ойлгож байгаа. Ирэх жилээс бол нэлээд энэ зээлийн талаар соён гэгээрүүлж, таньж мэдүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулж байгаа учраас энэ зээлүүд бол нэлээд идэвхтэй гарах байх гэж ингэж тооцоолж байгаа. Би Зээлийн батлан даалтын сангаар бол бас дорвитой юм гараагүй ээ. Аж ахуйн нэгжүүд.

Б.Саранчимэг: Нэмж хариулъя. 6 номер.

М.Ганхүлэг: Зээлийн батлан даалтын сан хуучин энэ Монголбанкны ТУЗ-ийн бүрэн эрх нь Монголбанкны харьяалалд байсан. Тэгээд сая 9 сард наашаа шилжиж ирж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга зээлийн батлан даалтын сангийн ТУЗ-ийг толгойлох болсон. Энэнээс өмнө ч гэсэн бид нар бас нэлээд хамтарч ажилласан. Тэгээд Зээлийн батлан даалтын сан бас өөрөө хуулийнхаа дагуу ингээд жижиг, дунд, үйлдвэрлэгчдэд тодорхой хэмжээний хураамжтай байдаг. Энэ хураамжийг бас зээл авч байгаа аж ахуйн нэгжүүдээс авдагтай холбоотойгоор энэ рүү бас аж ахуйн нэгжүүд иргэд маань өөрсдөө барьцаа хөрөнгийн шаардлага хангахгүй иргэд л ирж очиж хандаж байгаа.

Дээрээс нь дахиад банкны хүү дээрээс 1, 2 хувийн шимтгэл аваад эхлэхээр бас их төвөгтэй асуудал байсан учраас энэ дээр төдийлөн сайн зээлийн батлан даалтын сайтайгаа уялдуулж зээл гаргах ажил зоонохон хоцрогдмол байсан. Одоо бол бид нар энэ дээр бас тодорхой арга хэмжээнүүдийг авч дүрэмд нь өөрчлөлт оруулахаар ингээд ажиллаж байгаа.

Баярлалаа.

Б.Саранчимэг: Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Энэ Байгаль орчны сайд, Хөдөө аж ахуйн сайд нар хариуцсан мэргэжилтнүүд дарга нар байна л даа. Энэ жил маш их хуртай байсан. Манай энэ Усны газрын дарга Батбаяр маань ч гэсэн маш их пост хийсэн. Хөвд цөөрөм барих усыг нөөцлөх ингээд энийгээ бас эдийн засгийн эргэлтэд оруулах гээд. Ингээд энэ дээрээ та хэд ер нь ямар бодлого барив. Хэдэн төгрөг тавив, яаж энийгээ явуулах гэж байна. Одоо энэ байгалийн илүүдэл усаа бид нар яаж хадгалах юм, яаж буцаагаад энийгээ ашиглах юм? Зүгээр ер нь зүгээр говь болон энэ тал хээрт энэ малчид маань энэ хөвд суурин барих тал дээр ер нь зүгээр мэдээллийн түвшинд байгаа. Энийг хэзээ практикт амьдралд оролцуулах юм бэ? Хөдөө аж ахуйн яамныхан. Энэ дээр та бүхэн маань бас бодол санаагаа нэг хэлээдхээч. Тэгээд ер нь нэг зоонохон ингээд нөгөө бодлоготойгоо уялдуулж төсвөө авч явахгүй бол ер нь зүгээр нэг ийм ингээд асуудлууд дээрээ ингээд сэглэсэн сэглэсэн байдлаар асуудлууд та нар ингээд яриад байх юм аа. Ингээд эхлээд бодлогоо ингээд бүүр нэг ягштал нэг бодлогоо зөв болго л доо.

Тэр нөөцийн махны энэ асуудлаа хэзээ болих юм. Өнөөдөр Монгол Улсын үндэсний махны үйлдвэр гэж байхгүй болсон. Та хэд бүүр жишээгээр нь яривал өнгөрсөн жил Хятадын хөрөнгө оруулалттай махны үйлдвэрүүдээр бид

нар тэр нөөцийн махны асуудлуудаа шийдүүлсэн. Энийгээ хэзээ ингээд зөв болгох юм бэ? Нөөцийн мах гээд энэ асуудал чинь өнөөдөр үнэ тогтоогоод хавар нөгөө махны чинь үйлдвэрүүдийг бүгдийг нь ингээд дампууруулаад байгааг та нар ер нь ойлгож байна уу? Тэр хуртэл энд өнөөдөр энэ бодлого чинь хаана байна вэ гэдгийг би эргээд асууя.

Үндэсний үйлдвэрлэгч тэр махны үйлдвэрүүд чинь өнөөдөр байхгүй болчихлоо. Тэр сайддаа энэ хариуцсан яамных нь газрын дарга нар энэ бодлогоо зөв тайлбарлаж өг өө. Экспорт гэхээр ээмэг гэж ойлгоод байх юм. Тэгээд ээмэг дээрээ хамаг мөнгөө тавиад ингээд буруу бодлого явуулаад байна. Энэ чинь эхлээд л үе шаттай эцсийн асуудал нь тэр ээмэгжүүлэлтийн асуудал шүү дээ. Эрүүл бус малыг ээмэгжүүлээд яах гээд байгаа юм бэ тийм биз дээ? Тэгэхээр одоо энэ Нараа даргаас би нэг асуух гээд байна.

Өнөөдрийн энэ вакцины хяналтыг чинь хэн тавьж байгаа юм бэ? Хуучин Мэргэжлийн хяналтынхан гээд нэг хэдэн хүмүүс байдаг байсан. Одоо тэр хяналт чинь хаа байна? Яг энэ малчид буюу эцсийн өөрсдийн хэрэглэгч нар хяналтаа тавих боломж байна уу? Энэ вакцинууд дээр чинь бас индикаторууд байгаа шүү дээ тийм үү? Энийг энэ малчдадаа хэлж өг өө. Энийгээ орон даяар сурталчил. Тэгээд тэрийгээ эрүүл зөв тэр вакцинаа яг чанарын шаардлага хангасан вакцинаар тарьж байна уу, үгүй юү гэдгийг малчид маань өөрсдөө хянадаг тэр тогтолцоог нь олон нийтэд таниулах ажлыг сайн хиймээр байна аа. Тэгэхгүй бол өнөөдрийн бас тэр идээт буглаа үүсдэг нөгөө хүйтэн хэлхээний онолоо зөрчсөн, хортой ус аваачаад тарьж байна гэсэн үг шүү дээ шууд утгаараа. Энийгээ хянадаг тэр тогтолцоог малчдадаа маш сайн ойлгуул.

Тэгээд өнөөдөр тэр хүмүүс бид нарыг буцаад хүнс болгоод тэд нарын амьжиргааны асуудал шүү дээ. Энэ асуудлууд дээрээ анхаармаар байна аа. Тэгээд хувийн мал эмнэлгүүдийн

чадамжийг сайжруулах тал дээр тэр үнийг өсгөсөн тал дээр нь баяр хүргээд байх нь ч буруу байх л даа. Зүгээр энэнээсээ илүү л өндөр байх ёстой шүү дээ. Тэгж байж өнөөдрийн энэ хувийн энэ мал эмнэлгүүдийн чадамж чинь сайжраад, тэгээд өнөөдөр бид нар экспортод гаргах тэр боломжоо бид нар бий болгоно. Тэндээс нь нь одоо Сангийн яам татвараа аваад буцаагаад зөв хувиараа хий л дээ тийм биз дээ? Тэгэхгүй бол одоо ингээд экспорт дээрээ ингээд тодорхой бодлогын асуудлууд дээрээ Мал эмнэлэг нэгдүгээр асуудал шүү. Энийг нь эхлээд төсвөөсөө мөнгөөрөө гаргаад зөв болгочихвол тэртээ тэргүй мал эмнэлэг буцаагаад тэр хэмжээний мөнгөө тэр татвараар чинь ороод ирнэ шүү дээ тийм биз дээ, олоод өгнө өө Сангийн яамныхан. Тийм учраас зоригтой мал эмнэлэг дээр мөнгийг нь нэмж өг өө гэж хэлмээр байна.

Асуултууддаа хариулт авъя.

Б.Саранчимэг: Эхлээд Усны газраас 4 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Ганибал гишүүний асуултад хариулъя.

Нийт газар нутгийн 76.9 хувь их бага хэмжээгээр цөлжилтөд нэрвэгдсэн байгаа. Бид нар ялангуяа Байгаль орчин, аялал жуулчлалын яаман дээр нэгэнт цөлжилтөд нэрвэгдсэн газар нутаг, цөлжилтөд нэрвэгдэж байгаа газар нутаг, цөлжилт очоогүй буюу ногоон бүсээрээ байгаа газар нутаг гэдэг ангиллуудыг үүсгээд тодорхой хэмжээний хөвд, цөөрөм байгуулах болон гол ус мөрөнтэй холбоо бүхий тэжээгдэлтэй холбоо бүхий асуудлыг бид нар хөндөж байгаа. Цөлжилтийн хэмжээ баруун аймгууд руу ихээхэн хэмжээгээр явагдаж байна. Энэ жил бид нар баруун аймаг дээр бүтэн энэ зуны 2 сар гарангийн хугацаанд бас ажиллалаа. Хөвд цөөрмийн хувьд 2 янзаар бид нар төлөвлөж байгаа.

Яах вэ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийтдээ Завхан, Дундговь,

Хөвд гэсэн 3 аймагт 3 хөвд цөөрмийг 2024 онд байгуулахаар 536 сая төгрөгийг төсөвлөж оруулсан. Орон нутагтайгаа бид нар нэг зүйлийг ярьж байгаа. Тэр маань юу вэ гэхээр булаг шандыг хамгаалах хэлбэрээр хөвд цөөрмийг бий болгох. Энэ бол хамаагүй өртөг багатай ажил байгаа. Тухайлах юм бол Говь-Алтай аймагт 1176 орчим гол мөрөн булаг шанд байдгаас 117 булаг шанд жишээлбэл ширгэх аюулд учирсан. Энэ булаг шандуудаас улбаалаад байгуулагдах боломжтой хөвд цөөрмүүд гэж бий.

2023 оны хувьд бол Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам бол нийтдээ 200 гаруй булаг шандыг бол хашсан байгаа. Ингэснээрээ Монгол элснээс авхуулаад тодорхой цөлжилттэй байгаа газар нутгууд дээр хөвд цөөрөм байгуулах түүнийг дагасан тэрбум мод ойжуулах, зүлэгжүүлэх энэ ажлууд хийгдэх ёстой гэдэг ийм нэгдсэн төлөвлөгөөгөөр явж байгаа юм аа.

Хөвд цөөрмүүдээсээ гадна бид нар нэг зүйлийг маш сайн бодох ёстой. Тэр бол өнөөдөр байгаа нуурууд мөнх цаснуудаа яах вэ гэдэг асуудал, хамгийн их санаа зовоож байгаа. Ялангуяа ирэх жилийн хувьд бол Ганга нуур 2 дугаар шатыг Сүхбаатар аймагт бид нар эхлүүлж байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Монгол Улсын Ерөнхийлөгчийг Ерөнхий сайд байхад эхний шат хийгдсэн. 2024 онд бид нар 3 тэрбум төгрөгийг Ганга нуур дээр бол тавьж өгч байгаа. Хэрлэн гол, Өгий нуур, Говь-Алтай аймгийн Эрээн нуурын хувьд жишээлэх юм бол зайлигүй шинэчилсэн ТЭЗҮ байж Эрээн нуур, Ганга нуурын араас орж байгаа учраас тухайн нуурыг авч үлдсэнээр үүсэх боломжтой. Тодорхой газар нутгууд дээр хөвд цөөрмүүдийг бий болгох гэдэг ч юм уу. Тодорхой ажлууд бол ингээд үе шат дараалалтай хийгдээд явж байгаа гэдгийг би танд хэлэхийг хүсэж байна. Хур бол тодорхой хэмжээтэй байгаа.

Өнөөдөр бид нар хуримтлуулах технологитой холбоотой асуудлуудыг зайлшгүй хөндөх ёстой байгаа. Нэгэнт байгалийн энэ хур бороог хуримтлуулснаар эргээд бид нар байгаль эх дэлхийгээ чийгшүүлэх газар нутгаа бэлчээрээ хамгаалах энэ ажлууд зайлшгүй хийгдэх ёстой гэдэг ийм бодлого агуулгын хүрээнд явж байна. Гэхдээ энэ бол яг төлөвлөлтийн шатад бол эцэслэгдээгүй байгаа гэдгийг бас танд хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Б.Саранчимэг: Хөдөө аж ахуйн яамнаас 5 номерын микрофоныг өгье. Нэмж хариулъя.

М.Ганхүлэг: Ганибал гишүүний асуултад хариулъя.

Нөөцийн махтай холбогдолтой асуудал байгаа юм. Хүнсний тухай хуулийн хүрээнд стратегийн хүнсийг бэлдэх захиран зарцуулахтай холбогдолтой журмыг бас баталсан. Энэхүү журмын хүрээнд бол бүс орон нутаг өөрсдийн махны нөөцтэй холбогдолтой асуудлыг хариуцан ажиллахаар болсон. 2024 оны 1 сарын 1-ээс эхлээд. Тэгэхээр бол энэ жилийн улсын төсөвт Хүнс, хөдөө аж ахуйн яамны багц дээр бол нөөцийн махтай холбогдолтой төсөв тусгагдаагүй ээ. Энэ асуудлыг нийслэл яг өөрсдийнхөө хүрээндээ зохион байгуулаад явна. Журмаар бас нэлээн бас нарийвчлан зохион байгуулах ажлуудыг хийсэн. 2023 онд 15 зээлдэгч компанид зориулаад тодорхой бас төсвийг тусгаад ингээд ажилласан.

Хоёр дахь асуулт нь ээмэгжүүлэлттэй холбогдолтой асуудал малын бас эрүүл ахуйтай холбогдолтой асуулт асуулаа. Таны хувьд бас.

Б.Саранчимэг: Мал эмнэлгийн дарга нэмж хариулах уу? Нарантуяа 6 номерын микрофоныг өгье.

А.Нарантуяа: Ганибал гишүүний асуултад хариулъя аа. Мал эмнэлгийн мэргэшсэн хяналт гээд бид нар сая Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор өнгөрсөн 5 жилд бас дотроо хяналтын байгууллага байгуулаад тэгээд мал эмнэлгийн систем нь нэлээн бас гайгүй ер нь боломжийн түвшинд одоо бас нэг мал эмнэлгийн энэ хууль тусгаарласан босоо тогтолцоотой болсон. Энэ үйл ажиллагааны хүрээнд илтгэх барих нэг тийм хамгийн сайн ажил байгаа. Одоо бол харин би бас Ганибал гишүүнд бас далимдуулаад Байнгын хорооныхонд бас дуулгачихъя гэж бодож байна. Яагаад гэхээр та бас хэллээ. Мал эмнэлэг бол өөрөө олон улсын хорио цээрт өвчинд баталгаажуулалт олгодог байгууллага учраас салбарын хяналт энэ мал эмнэлгийн энэ тогтолцоо ялангуяа махны үйлдвэрийн техникийн зохицуулалт энэнд оролцоод байгаа асуудал байгаа.

Тийм учраас та бүхэнд өргөн барьж байгаа хууль дээр бас анхаарах.

Б.Саранчимэг: Баярлалаа. Ганибал гишүүн тодруулъя. Саналаа хэлэх юм уу, тодруулъя.

Н.Ганибал: Яах вэ ингээд төсөвтэй холбоотой Сангийн яам байна. Эдийн засгийн яамныхан байгаа юу. Тэгээд одоо нэг ийм асуудал байна. Энэ нэг сангууд байна шүү дээ. Нэн ялангуяа энэ Хөдөө аж ахуйн ямаар дамжуулаад нэг хөнгөлөлттэй зээлүүд олгодог энэ асуудал урт хугацааны бодлого болчихлоо. Энийгээ болимоор байна. Энэ чинь уг нь нэг богино, нэг удаагийн арга хэмжээ байхгүй юу. Одоо нөгөө бүх банкнууд чинь бүгдээрээ хөдөө аж ахуйн салбар луу ороод ирсэн. Тэгээд тэндээсээ мөнгө авангуутаа зээл болгоод ингээд явдаг ийм тогтолцоо руу бүгдээрээ ингээд Монгол Улс орчихлоо. Энийгээ зогсооё оо. Энэ дээрээ та нар зоригтой энэ бодлогуудаа гарга. Тэгэхгүй бол бид нар ингээд урт хугацааны бодлого дээр мэдээж тэнэг хүн гэж юу байх вэ дээ банкнууд бүгдээрээ

хөдөө аж ахуйн салбар луу ороод ирсэн. Тэгээд тэр чинь нөгөө нэг хөнгөлөлттэй зээл болоод татаасныхаа хүүг төрөөс аваад ингээд амьдраад байна. Энийгээ зогсоох тал дээр та хэд маань нэгдсэн бодлогоо гарга. Тэгэхгүй бол энэ чинь урт хугацааны бодлого биш шүү гэдгийг бас хэлье ээ.

Б.Саранчимэг: Санал байна. Бейсен гишүүн асуултаа асууя.

Б.Бейсен: Байгаль орчны сайдаас асууя. Энэ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн энэ жагсаалттай танилцлаа л даа. Уг нь аялал жуулчлалын байгалийн түүх соёл, өв бүхий газрууд болон ариун цэврийн байгууламж, авто зогсоол, отоглох газартай байх ёстой гээд тэгж байгаа. Энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт ч байгаа. Алтай Таван богдын аялал жуулчлалын бүсэд ингээд 2024 он хүртэл ингээд байгуулна. Ашиглалтад оруулна гээд заачихсан байгаа. Жилдээ 25-аас 30 мянган гадаад, дотоодын жуулчид явж байгаа. Тэр Алтай Таван богд уул, Хотон нуур, Хурган нуур нөгөө Цагаан гол гээд Сүүн гол гээд заншсанд тэр голуудаар явдаг.

Гэтэл энэ байгаль орчин ихээр бохирдож байна. Ерөөсөө бэлчээр ихээр сүйтгэгдэж байна. Энэ машин техникээр. Энэ дээр төсөл хөтөлбөрт оруулаагүй юм уу, аль эсвэл энэ аялал жуулчлалын байгалийн түүх соёл, өв бүхий газрууд, ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг улсын хэмжээнд гээд 2 тэрбум 325 сая төгрөг тавьсан байна. Энэ дотор байна уу? Энэ талаар асууя.

Нөгөө талаар байгаль орчны аялал жуулчлалын салбарын тоног төхөөрөмж гээд 5 тэрбум тавьсан байна. Энэ яг энэ аль аль аймагт тавигдсан? Улсын хэмжээнд гээд тэгсэн байна. Чухам ямар тоног төхөөрөмж авах вэ энэ талаар асууя.

Хөдөө аж ахуйн сайдаас асуух асуулт. Мөн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт малын түүхий эд, махнаас бусад түүхий эдийг боловсруулах үйлдвэр барина гэсэн. Энэ дээр зүгээр Дарханы арьс ширний үйлдвэр дээр 23 тэрбум тэгээд санхүүжих нь 11 гэж байна л даа. Нөгөө талаар Ховдын Жаргалант дээр малын гаралтай түүхээ цэвэрлэх байгууламж гээд байна. Боловсруулах үйлдвэр барих тал дээр энэ төсөл хөтөлбөр ирээгүй юу энэ дээр яагаад тавихгүй байна. Ер нь бүх юм үнэгүйдэж байна. Малчид түүхий эд зарагдахгүй байна, арьс ч зарагдахгүй байна гэж байна. Зөвхөн арьс шир ноос ноолуураар тогтохгүй малын дотор эрхтэн яс боловсруулах үйлдвэрүүдийг барих боломж байгаагүй юм уу? Төсөл хөтөлбөр өгсөн үү өгөөгүй юу? Энэ талаар ямар бодлого баримталж байна?

Б.Саранчимэг: Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Эрдэнэ хариулъя. 4 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Уур амьсгалын өөрчлөлтөөс авхуулаад олон асуудлууд бий. Бейсен гишүүн маань бас зөв асуудал хөндөж байгаа. Алтай Таванбогд хайлалт маш өндөр явагдаж байгаа бүс нутгийн нэг.

Гэхдээ бид нар зөвхөн байгаль эх дэлхий рүү бурууг чихэх хэрэггүй. Хүний нөлөөлөл маш өндөр байгаа. Алтай Таванбогд дээр. Тийм учраас бид нар 2023 оны 8 дугаар сарын 1-ээс авхуулаад Алтай Таванбогд руу машинаар очихыг бол хориглосон. Харуулын цэгээс цааш ердийн хөсөг хэрэглэх ийм шийдвэрийг гаргасан байгаа. Энэ бол энэ намаржингаа нэлээн олон юм боллоо. Казах иргэд маань ч бас тодорхой хэмжээнд хариуцлагагүй хандсан зүйлс бий.

2.3 тэрбум дотор отоглох цэг байгуулах Алтай Таванбогдын нэг төсөл орсон байгаа. Би түрүүн хэлсэн Тусгай хамгаалалттай газар нутгийг ялангуяа хамгаалалтын захиргаадүүд

менежментийн хэлбэрт шилжсэнээр өөрсдөө цаашидаа тодорхой хэмжээний менежментийн ажлуудыг хийж явж байх ёстой гэж. Энэ ажлууд бол хийгдэнэ. Оны төгсгөлөөр Алтай Таванбогдод очсон жуулчдын тоогоор тодорхой төвлөрсөн хөрөнгө оруулалтуудыг бас төсвийг мэдээлэх байх.

Хоёрдугаарт, Тусгай хамгаалалттай газар нутаг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд бид нар хувийн хэвшилтэй хамтын ажиллагааны хүрээнд отоглох цэг болон аялал жуулчлалын томоохон баазуудыг байгуулах, байгаль орчинд ээлтэй хэлбэрээр шийдэхээр газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнүүд явж байгаа. Энэ ажлууд бол 2024 онд бол хийгдэж эхэлнэ ээ гэдгийг би бас албан ёсоор хэлэхийг хүсэж байна. Бид нар бол аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 5 сарын 4-ний өдөр баталсантай холбогдуулаад улсын аялал жуулчлалын бүсийн журмыг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд оруулахаар бэлтгэж байна.

Энэ дээр бол Алтай Таванбогд бас томоохон байр суурийг эзэлж байгаа. Алтай Таванбогдыг тойрсон мөн Баян-Өлгий аймгийг тойрсон аялал жуулчлалын томоохон зайлшгүй очих ёстой ийм бүсүүд бол олон бий гэдгийг бас энэ удаа хэлье. Тоног төхөөрөмжийн 5 тэрбумын хувьд 2023 оныг Байгаль орчны яам цаг уурчдын жил болгож зарласан. Цаг уурчдын маань хувьд бол хамгийн их орхигдсон ийм салбар болсон. Ус цаг уурын орчны шинжилгээний тоног төхөөрөмжүүдийн хөрөнгө оруулалт дээр бид нар 5 тэрбум төгрөгийг тавьж өгч байгаа. Энэ бол ус цаг уур орчны шинжилгээ дээр тавьж байгаа мөнгө гэж ойлгож болно.

2007 оны компьютер хэрэглэж байна. Сая энэ зун би Ногоон нуур, Цагаан нуур, Өлгий гээд нэлээн хэдэн сумдаар би очиж ажилласан. Ингээд ажиллаад явж байхад ялангуяа сумдууд дээрх цаг уурын өртөөнүүд маань бол компьютергүй

компьютер нь эвдэрсэн, өнгөт принтергүй. Ялангуяа нислэгтэй газруудаар бол заавал өнгөт принтерээр хэвлэж авч ир гэдэг ийм шаардлага тавьдаг. Гэсэн мөртөө навигацийн орлогоос ус цаг уур руу тодорхой хэмжээний мөнгө ордоггүйтэй холбогдуулаад тэрийг шинэчлэх ямар ч боломж байдаггүй. Зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдэхээр ажилладаг ийм хэлбэртэй байгаа. Гэх мэтчилнээр бол энэ тоног төхөөрөмжийн 5 тэрбум дээр бол бид нар наад захын шаардлага хангаж ажиллах энэ тоног төхөөрөмжүүдийг бол бэлдэж авна гэдэг ийм төлөвлөгөөтэй байгаа.

Бид нар БНСУ, БНХАУ гээд олон улсын түвшинд бусад орнуудын Турк улс гээд цаг уурын байгууллагуудыг судалж байна. БНСУ Ус цаг уурын хувийн байгууллагуудтай юм байна лээ. Яаж ашигтай ажилладаг вэ? Яаж менежментийн түвшинд ажилладаг вэ? Навигацийн орлогоос тодорхой хэмжээний мөнгийг цаг уур орчны шинжилгээ рүүгээ хуваарилдаг маш олон орон байна. Энэ дээр бол бид нар бас тодорхой хэмжээний турилага судалгааны ажлуудыг эхлүүлээд ингээд хийхээр.

Б.Саранчимэг: Баярлалаа. Бейсен гишүүн тодруулъя гэж байна.

Б.Бейсен: Би сая энэ ариун цэврийн байгууламж, авто зогсоол, отоглох газар гээд 2 тэрбум 325 сая тавигдсан гээд хэлсэн шүү дээ. Энэнээс тэр Алтай Таванбогдын аялал жуулчлалын бүсэд юм тавигдах уу? Байгаль орчныг үнэхээр сүйтгэж байна гэж хэллээ. Та бас сая ард иргэд сүйтгэж байгаа юм шиг ярилаа л даа. Тэгэхгүй бол үнэхээр бохирдож байна, ус бохирдож байна, бэлчээр устаж байна. Энэ асуудал дээр энэ жил байна уу гээд асууж байгаа юм.

Б.Саранчимэг: 4 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Бейсен гишүүн олон үгэн дотроос анзаараагүй юм шиг байна. 7 цэгийн нэг нь Алтай Таванбогд гэж хариулсан. Баярлалаа.

Б.Саранчимэг: Баярлалаа. Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Г.Мөнхцэцэг: Говийн нөхцөлд худаг ус бэлчээрийн доройтол, мөн отор нүүдлийн хөлд дарагдсан, талхлагдсан гээд ингээд нэлээн их олон асуудлууд байгаад байгаа. Тэгээд энэ Шинэ хөдөө төсөл гэдэг энэ төслийг бидний гишүүд бас 2017 оноос хойш санаачлаад ингээд үндсэндээ 7 дахь жил рүүгээ ороод ингээд явж байгаа юм аа. Энэ төслийн хүрээнд бас нэлээн олон зүйлийг ялангуяа говийн бүсэд бас хийж үр дүнгээ өгч байгаа гэж бас ингэж санаачилсан хүний хувьд бас үзэж байгаа. Ялангуяа бас говийн энэ хүндрэлтэй байдал нөхцөлүүдийг бас харгалзан үзээд бид бас хүлэмжжүүлэх ажлыг бас нэлээн эрчимтэй ажиллаад ингээд явж байгаа юм аа.

Ялангуяа Дундговь аймгийн хувьд бас хүлэмжжүүлэх ажлыг нэлээн хийсний үр дүнд өнөөдөр бас ургац хурааж авдаг, ялангуяа энэ ургац нь говийн нөхцөлд ургасан, говийн хөрсөнд ургасан, энэ өвс ногоо их амттай байна гэдгийг говийн мал бас мах нь амттай байдагтай адилхан энэ нөхцөлд ургасан төмс хүнсний ногоо их амттай байна гэж ингэж ингэж ярьдаг болсон. Тэгээд Говьсүмбэр, Дундговь аймгуудад бас ингэж хэрэгжүүлэхээр 1.5 тэрбум төгрөгийг суулгаад энэ 2024 оны төсөв дээр ингээд явж байгаа.

Тэгээд энэ төслийнхөө хүрээнд бид нар бас нэлээн олон ажлуудыг цаашаа үргэлжлүүлээд хийнэ ээ гээд. Ингээд ер нь энэ төслүүдийг хэрэгжүүлэхдээ бид нар мэдээж тухайн нутгийн ард иргэдийн саналыг ялангуяа малчдынхаа саналыг авч байж энэ төсөвт суулгадаг. Тийм болохоор энэ ард иргэд маань юу хүсэж байна вэ гэхээр ер нь бид нар өрхийн үйлдвэрлэлийг дэмжмээр байна. Ялангуяа

Шинэ хөдөө төслийнхөө хүрээнд та нарын хийсэн ажлууд тодорхой хэмжээгээр үр дүнд хүрч байгаа ч гэсэн ялангуяа энэ ЖДҮ-ийг хөгжүүлэх, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тал дээр Шинэ хөдөө төслөө цаашид үргэлжлүүлж өгөөч ээ гэдэг ийм саналуудыг тавиад байгаа юм аа.

Тэгэхээр бид нар энэ төслөө хэдийгээр санаачилсан төслийнхөө хүрээнд энэ ажлуудыг хийж байгаа ч гэсэн бас яг ямар нэгэн байдлаар энэ яам өөрөө бас бодлого зохицуулалт хийгээд энэ ажлуудыг бас цаашид нь үргэлжлүүлэх шаардлагатай байгаад байгаа юм. Тэгэхээр энэ ЖДҮ-ийг дэмжих сан дээр ер нь ямаршуухан ажлуудыг хийхээр ямар төсвүүдийг тусгаад ингээд явж байна вэ? Энэ дээр одоо бас ямар санал байна? Бас малчдаас маань бас санал ирдэг. Ялангуяа бид нар бас малын тоо толгой гэхээсээ илүү малын чанарыг эрхэмлэх шаардлагатай байна гээд. Тэгэхээр энэ малын тоо толгойг бас өсгөх дээрээ мэдээж малын үүлдэр угсааг сайжруулах малаа чанаржуулах ажлуудыг яг бас хийх ёстой.

Тэгэхээр энэ үүлдэр угсаа сайжруулах тал дээр ер нь бас хөдөө аж ахуйн яам ингээд үндсэндээ ямаршуухан төсөв, төлөвлөгөөг энэ 2024 оны төсөвт суулгав гэдэг ийм 2 зүйлийн асуулт байна.

Байгаль орчны яам Байгаль орчны яам аялал жуулчлалын асуудлыг хариуцдаг ер нь тэгээд энэ соёлын аялал жуулчлал энэ аялал жуулчлалын нэлээд хэсэг нь говь руу чиглэгдсэн ийм аялал жуулчлал говь руу зочилсон ийм аялал жуулчлал байлаа.

Тэгэхээр ер нь говийн нөхцөлд отог бааз байгуулах гээд нэлээн олон хүндрэлтэй асуудлууд бас гар дагаж гараад байдаг л даа. Тэгэхээр яг энэ Соёлын аялал жуулчлал гэдэг чиглэл рүү бас яг Байгаль орчин, аялал жуулчлалын яам үнэхээр одоо энэ 2024 онд төсөв дээр

ямариуухан өөрчлөлт оруулахаар юмнуудыг тусгав гэж?

Дээр нь бас энэ усны асуудал нэлээн хүнд байгаад байгаа. Усны хуульд өөрчлөлт оруулах энэ асуудлыг бас 2, 3 жил бид нар бас ярьж байна аа. Энэ хууль дагаад хийгдэх ажлууд бас зөндөө байгаад байгаа. Энэ хуульд хяналт шалгалт хийх энэ тэр гээд нэлээн олон ажлууд байгаад байгаа. Яг Усны агентлаг бие даасан энэ төсвөөрөө юу хийхээр ингээд бас төлөвлөөд ингээд явж байгаа юм бэ? Ер нь жоохон нэмж өгөх шаардлагатай гэж бас үзэж байгаа.

Дээр нь бас Тусгай хамгаалалттай газар нутгуудын тухай хууль ингээд багцаараа газрын хуультай орж ирэхээр ингээд л яригдаад ингээд байгаад байгаа. Тэгэхээр бид нар энэ тусгай хамгаалалтад авах газар нутгуудын талбайн хэмжээг нэмэх тал дээр бас мэдээж төсөвт суулгаж байж тодорхой хэмжээний ажлуудыг дорвитой үр дүнтэй хийнэ. Энэ чиглэлийн юмнууд дээр Байгаль орчны яаман дээр ямариуу төсвүүд тавигдаж. Ер нь цаашид юу хийх ёстой шаардлагатай гэдэг дээрээ бас энэ төсвүүдийг тавив гэдэг дээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ингээд 2 зүйлийн асуултыг тавьж байна.

Б.Саранчимэг: Эхлээд Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хариулъя. 5 номерын микрофоныг өгье.

М.Ганхүлэг: 2024 оны төсөвт мал үржүүлэхтэй холбогдолтой үржлийг сайжруулахтай холбогдолтой орсон 2 ажил байгаа. Үржлийн хээлтүүлэгч болон цөм сүргийн хээлтэгч малыг ялган төвлөрүүлэх замаар мэргэжилтний хяналтад авах гэдэг энэ ажил үйл ажиллагааны хүрээнд 500 сая төгрөг төсөвлөсөн байгаа. Малын удмын санг хамгаалах, мал үржүүлэг, технологийн ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн нэгжийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр бас 500 сая төгрөг орсон байгаа. Энэ бол үйл ажиллагааны зардал.

Гол ажлууддаа тусгагдаад ингээд явна. Хамгийн гол нь мал үржүүлгийн үйл ажиллагаатай холбогдолтой хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх Их Хурлын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн тодорхой мал аж ахуйн хэсэг дээр бол энэ төрлийн бас үйл ажиллагааг явуулах зээлүүдийг бас авч хувийн хэвилийнхэнтэй бас хамтран ажиллах энэ боломжууд нь бас нээлттэй байгаа. Мөн одоо яг тодорхой бүс нутгуудад аймгуудад Шинэ хөдөө төсөл хэрэгжиж байгаа. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд бас зөвхөн хүлэмж газар тариалан гэхээс гадна мал аж ахуйн чиглэлээр энэ үржүүлгийн чиглэлээр бас тодорхой ажлууд бас хийгдээд явахаар тусгагдсан байгаа.

Ирэх жил жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх санд 50 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг төлөвлөсөн байгаа. Улсын төсвөөс бол тодорхой үйл ажиллагааны зардал дээр 1 тэрбум төгрөгийг оруулсан. Яг одоо зээлийн санхүүжилтийг бол өөрсдийн өмнөх зээлийн эргэн төлөлтөөр зохион байгуулаад явна. 70 орчим хувийг бол орон нутгийн үндсэндээ жижиг, дунд бизнес эрхлэгч нарыг дэмжих энэ чиглэлээрээ бас зохион байгуулаад явна аа. Шалгаруулалт үйл ажиллагааг бол бид бүхэн газар тариалан болон мал аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч нараа бас тооцож үзээд 1 сарын бас хамгийн эхний ажлын 7 хоногийн эхэнд үндсэндээ энэ жилийн жижиг, дундын зээлийн шалгаруулалт үйл ажиллагааг зарлана гэсэн ийм байдалтайгаар ажиллаж байгаа юм аа.

Б.Саранчимэг: 4 номерын микрофоныг өгье. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Аялал жуулчлалын асуудал бол цогц асуудал. Энэ өөрөө 16 салбар хамаарсан ийм салбар. Соёлын яам, Гадаад харилцааны яам, Зам, тээврийн

хөгжлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам гэх мэтчилнээр яамдууд бол нэг кабинетын зарчмаараа маш сайн ажиллаж байгаа. Тийм ч учраас заримдаа Аялал, жуулчлалын яам, Соёлын яам юм уу? Соёлын яам Аялал жуулчлалын яам юм уу гэдэг төөрөгдөл хүртэл үүсэхээр хэмжээнд байгаа гэсэн үг. Соёлын яамтай хамтарсан байдлаар бид нар Гадаад харилцаан яамтай хамтарсан байдлаар тухайн оны төлөвлөгөөг урьдчилсан байдлаар бид нар оны эхэнд баталдаг. Энэ оны төлөвлөгөөг бид нар 11 сарын 20 гэхэд 2024 оны төлөвлөгөөг батлахаар бол Гадаад харилцааны яам болон Соёлын яамтай ажиллаад явж байна.

Соёлын аялал жуулчлалтай холбоо бүхий асуудлуудыг бид нар зайлшгүй анхаарах ёстой. 2023 оны аялал жуулчлалын төсөв 4.9 тэрбум төгрөг байсан. 2024 онд бид нар 13 тэрбум төгрөг болгож оруулж байгаа. 3.1 тэрбум нь бол 55 тэрбумын зээлийн хүүгийн татаасанд буюу Аж ахуйн нэгжүүдийг дэмжих хэлбэр дээр явж байгаа. Үлдсэн 9.9 орчим тэрбум төгрөг бол аялал жуулчлалын хөтөлбөрүүдийнхээ дагуу зарцуулагдахаар ингэж төлөвлөгдөж байгаа.

Соёлын аялал жуулчлал дээр Тайланд, Вьетнам гэх мэтчилний орнуудаас хүсэлтүүд ирээд бид нар ажиллаад явж байна. Жишээлбэл Тайландаас цантай холбоотой соёлын аялал жуулчлалыг хэрэгжүүлэх манай Манзушир хийд дээр төвлөрөх, Вьетнамаас шашны аялал жуулчлал дээр төвлөрөх тэр нь Манзуширын хийд дээр төвлөрөх түрүүний цам нь болохоороо Амарбаясгалант хийд. Манзуширын хийд дээр төвлөрөх гэх мэтчилэнгийн ийм ажлууд бас явагдаж байна аа. Тэгээд соёлын аялал жуулчлал дээр бол бид нар аялал жуулчлалыг ялангуяа 2024 оны хийх Засгийн газраас батлах ивент арга хэмжээний төлөвлөгөөнд нүүдэлчдийн соёлын наадам манай Соёлын яам

дангаараа хариуцаж хийдэг. Түүнээс бусад нь бол бас тодорхой хэмжээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Соёлын яам, Гадаад харилцааны түвшинд хамтын ажиллагааны хүрээнд явна гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Дээрээс нь соёлын биет бус өвтэй холбоо бүхий асуудлууд хөндөгдөж байгаа. Дэл уул Дундговь аймаг энэ жил бид нар очсон. 5 мянга гаран хадны зураг, сүг зураг, бичээс, уламжлал, соёл илэрхийлсэн 32 хүний бүжиг гэдэг ч юм уу ингээд маш олон зүйлүүд байгаа. Тэгээд Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр бид нар 14 газар нутаг буюу нийтдээ 2153540 га газрыг бол улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөж байгаа. Үүний тодорхой хувь нь бол энэ соёлын чиглэлээр бас соёлын өвд бүртгэгдсэн ийм газрууд байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Усны асуудал дээр бол Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, бусад хууль тогтоомжтой холбоотой асуудлуудыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос үүрэг өгсний дагуу Байгаль орчны яам ажиллаад явж байгаа.

Усны тухай хуулийг 2023 оны намрын чуулганд өргөн барихаар бэлдээд бүх юм бэлэн болсон. Ингээд явж байна. Устай холбоо бүхий асуудал дээр бид нар давхцуулж уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хуулийг зайлшгүй санаачлах шаардлагатай гэж үзэж байгаа. Усыг дангаар нь хуульчлаад тодорхойлсон 100 хувийн цогц арга хэмжээ болж чадахгүй ээ гэдгийг бол Байгаль орчин, аялал жуулчлалын яам тодорхойлж байгаа. Тэр утга агуулгынхаа хүрээнд бид нар бас уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудалтай усыг бол холбож авч үзэж байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна. Нийт тавигдсан хөрөнгө оруулалтын хувьд бол 12.4 тэрбум төгрөг, усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрийн хэлбэр дээр бол 2024 оны төсөвт бол тавигдсан байгаа. Баярлалаа.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр ажлын хэсгийнхэнд баярлалаа. Маши тодорхой бас хариулт авч байна. Тэгээд цаашидаа бид нар бас өнөөдөр энэ 2 дахь хэлэлцүүлэг байгаа. Тэгэхээр энэ хэлэлцүүлэгтэй холбогдуулаад бас энэ төслийн талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар би гуравхан асуулт асууя.

Засгийн газрын танилцуулгад энэ 2024 онд хүнс үйлдвэрлэл хөдөө аж ахуйн салбарын бодлогыг цогцоор нь шинэчилнэ гэсэн байгаа. Тэгэхээр энэ бодлогын шинэчлэлийн хүрээнд яг томоохон ямар арга хэмжээг оруулсан байгаа вэ? Ер нь энэ арга хэмжээгээ дагаад хууль эрх зүйн шинэчлэл хийхээр төлөвлөж байгаа юу? 36 дугаар тогтоолын дагуу бас 2 яамнаас ялангуяа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 6 хуулийн төсөл орж ирэх байсан. Одоо болтол орж ирээгүй байгаа. Тэгээд ингээд энэ тал дээр нэг тодруулга авъя.

Нөгөө талаар бид нар байгалийн нөөц ашигласны болон энэ байгалийн орчныг бохирдуулсны төлбөрийн орлогын тодорхой хувийг бас байгаль орчноо хамгаалах нөхөн сэргээхэд зарцуулах ёстой байдаг. Гэвч одоо зориулалтын дагуу зарцуулахгүй. Өнөө гүйцэтгэл нь 40-өөс дээш хувь гарахгүй байгаа. Тэгэхээр ирэх оны төсвийн төсөлд туссан орлого, зарлагын талаар Сангийн яам энэ дээр бас нэг хариулт авахыг хүсэж байна. Бид нар өнөөдөр байгалиа хамгаалаад ус бохирдуулсны төлбөр гээд баахан мөнгө Сангийн яаман дээрээ, Төрийн сан дээр төвлөрчхөөд байдаг. Энэ нь эргээд яг нөгөө Байгаль хамгаалах сандаа орох байсан чинь бас ороогүй байгаа.

Тэгэхээр энэ дээр нэг тодруулга авъя.

Нөгөө талаараа 2024 онд энэ бизнес эрхлэгчид тулгарч байгаа саад бэрхшээлийг шийдвэрлэхэд энэ төрийн зохицуулалтыг хялбарчилна гэсэн байгаа.

Тэгэхээр байгаль орчны үнэлгээг гол нь хялбаршуулна гэж оруулж ирсэн. Тэгэхээр яаж хэрхэн хялбаршуулах гэж байгаа вэ? Энэ хялбаршуулсан зохицуулалт байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөл гарах сөрөг үр дагаврын эрсдэл бий юу? Ингээж хялбаршуулахдаа эрсдэлийг тооцсон байгаа юу гэсэн ийм асуултууд байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас эхлээд хариулъя. 5 номер.

М.Ганхүлэг: Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Хүнс үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбогдолтой Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилгаар зүй явагдаж байгаа Хүнсний хангамж аюулгүй байдлыг сайжруулах чиглэлийн энэ хөтөлбөрийн арга хэмжээний эхний жил 2023 онд хийгдлээ. Үргэлжлүүлээд 2024 он үйл ажиллагаагаа илүү сайжруулаад банкнуудаар олгогдож байгаа зээлүүдийн бас энэ хамрагдалтыг илүү нэмэгдүүлэх энэ чиглэлийн ажлууд дээрээ Хүнс, хөдөө аж ахуйн онцлон анх анхаарч анхаарал хандуулж ажиллана.

Энэхүү бас хүнсний үйлдвэрүүдийг дэмжсэн зээлүүдийг үргэлжлүүлэн олгох энэ гол ажлууд үргэлжлээд явна аа. Бид бүхний гол үндсэн стратеги зорилт бол дотооддоо өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнээ 100 хувь үйлдвэрлэдэг ийм улс үндэстэн болох энэ санаачилгыг гол бодлогоо болгож явж байгаа. Эхний жилийн үр дүн бас тодорхой үр дүнгээ өгөөд ингээд газар тариалангийн салбар дээр нэлээдгүй бас эргэлтүүд бас бий болоод явж байгаа. Хүнсний үйлдвэрлэлийн худалдаа үйлчилгээний энэ салбар дээр бол бас үргэлжлүүлээд явна. Тодорхой бас сүүний урамшуулал. 36 дугаар тогтоолын энэ хэрэгжилтийг хангах энэ ажлууд бас 2024 оны төсөвт суутгагдсан байгаа. Тэгээд сүүний урамшууллыг бас нэмэгдүүлж дотоодын сүүний хэрэгцээг бас хангах энэ чиглэлийн ажлууд бас 2024 онд нэлээн бас ач

холбогдол өгөхөөр бид бүхэн бас оруулсан байгаа гэдгээ хэлье.

Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн тэр дундаа хүнсний ногооны чиглэлээр 2023 оны энэ үйл ажиллагаанууд бас үр дүнгээ өгсөн. Бид бүхэн дотоодынхоо хэрэгцээндээ 70 гаруй хувийнхаа хүнсний ногооны хэрэгцээг хангаж байсан бол энэ жилийн байдлаар бол бид бүхэн 81.2 хувийг бол дотооддоо бүрэн хангадаг бас 80 хувь давсан. Ирэх жил бол энэ байдлаа нэмэгдүүлэх бусад нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнүүдээ бас нэмэгдүүлэх чиглэлээр анхаарч ажиллана.

Салбарын хууль тогтоомжтой холбогдолтой 6 төрлийн хуулийн төсөл боловсруулагдаад ажлын хэсгүүд ажиллаад ингээд явж байна.

Хоёр хуулийн төслийг ялангуяа ургамал хамгаалалттай холбогдолтой 2 хуулийн төслийг Засгийн газарт өргөн барьсан байгаа. Бусад хуулийн төслүүдийг бас ажлын хэсгийнхэн ажиллаад багц байдлаар оруулахаар ажиллаж байна аа.

Б.Саранчимэг: Баярлалаа. Сангийн яамнаас хариулъя. 2 номерын микрофоныг өгье.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Байнгын хорооны даргын асуултад хариулъя аа. Тэгэхлээр байгаль орчны орлогууд бол ихэнх нь сум дүүргийн төсөвт бол төвлөрдөг. Төрийн санд бол төвлөрдөггүй байгаа. Жишээ нь Төсвийн тухай хууль дээр бол 23.8.4 дээр ан агнуурын нөөц ашигласны төлбөр ан амьтан агнах барих зөвшөөрлийн хураамж бол сум дүүргийн төсвийн орлого, дээрээс нь ойн хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр, хог хаягдал, ногоон төлбөр гээд. Ер нь байгаль орчинтой холбоотой ихэнх усны төлбөр гэх орлогууд бол орон нутгийн орлого болчихоод байгаа юм. Тэгээд

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиараа бол эдгээр орлогыг бол буцаагаад тухайн зорилтуудад нь бол 50-аас дээш хувиар бол зарцуулах хуулийн заалттай байгаа.

Сум дүүргийн орлого бол өөрөө бол сум дүүрэг бол өөрөө бас иргэдийн төлөөлөл нь өөрөө төсвөө баталдаг. Сангийн яамнаас бол энэ дээр бол батлахад нь оролцох боломжгүй байдаг. Тэр тухайн иргэдийн төлөөлөгч нар нь бол өөрсдөө бас иргэдээс сонгогдсон саналын эрхтэй төсөв батлах эрхтэй байдаг. Тэгээд энэ дагуугаа бол төсвөө батлаад явдаг. Байгаль орчны яамнаас бол энэ дээр бол дэвшилттэй нэг зүйл бол сүүлийн 2 жилийн дотор оруулж ирж байгаа. Энэ бол системээр бүртгэх асуудал орж ирж байгаа юм. Хэдий хэмжээний байгалийн нөөц ашигласны байгалийн орлого бол орж ирж байна гэдгийг нэг талдаа бол системээр бүртгээд орлогыг нь тавиад, нөгөө талдаа тухайн дүүрэг, сум дүүрэг, аймаг нь бол энийгээ яг зарцуулж байна уу гэдгийг бол мөргөж өгөгдсөн төсөв дээр бол тодорхой төсөл НҮБ-тай хамтарч бол хэрэгжүүлээд энэ нь тодорхой үр дүнд бол хүрээд явж байгаа юм.

Сангийн яамны хувьд бол энийг бол 100 хувь дэмжиж байгаа. Цаашидаа бол яг энэ нь тухайн олсон орлогыг нь буцаагаад тэр байгальд нь зарцуулах байгалийн төлбөрийг байгальд нь зарцуулах энэ асуудал дээр бид дэмжиж ажиллаж байгаа. Системийн хувьд бол боломжтой болчихсон учраас 2024 оны төсвөөс бол бид энэ улсын төсөв батлагдсаны дараа орон нутгууддаа чиглэл хүргүүлээд танай дээр яг ийм ийм орлогууд хянагдсан байна. Ирэх жил ийм орлогууд орохоор байна. Энийгээ буцаагаад зарцуул гэдэг бол тэр зүй ёсны шаардлага нь тавиад хууль хэрэгжүүлье гэдэг тэр удирдамжаа өгөөд явна. Тэгээд одоо системээр хянах боломжтой учраас энэ дээр бол давхардал, хийдэл гарахгүй, бүрэн хянах боломжтой гэж үзэж байна.

Б.Саранчимэг: Тийм 4 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Саранчимэг даргын асуултад хариулъя. Байгалийн бодис ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт 2021 онд 26 хувтай байсан. 2022 онд бид нар АТГ-тай хамтарч ажилласнаар 43 хувьд хүргэсэн. 2023 оны урьдчилсан дүгнэлтээр 80 хувьд хүрэх болов уу гэдэг ийм ойлголттой өнөөдөр байна. Улсын ерөнхий прокурорт хандсан. Цагаан дээр хараар бичигдсэн хууль энэ хуулийг албан тушаалтнууд хэрэгжүүлэх үүрэгтэй. АТГ-тай хамтарч ажилласнаар хууль хяналтын байгууллагуудтай хамтарч ажилласнаар тодорхой үр дүнгүүд яалт ч байхгүй гарсан. Жишээлбэл Баян-Өлгий аймаг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт 0 хувь байдаг байсан. 2022 онд 35.5 хувьд очсон. Энэ бол дэвшил. Гэхдээ 100 хувь байх ёстой. Баян-Өлгий аймаг 2022 онд 35.5 хувь, Говь-Алтай аймаг 26.4 хувь, Говьсүмбэр аймаг 48.7 хувь, Дундговь аймаг 21.1 хувь, Орхон аймаг 33.5 хувь, Сэлэнгэ аймаг 17.7 хувь, Төв аймаг 20.9 хувь, Улаанбаатар 17.1 хувь, Ховд аймаг 31.8 хувь, Хөвсгөл аймаг 29.7 хувь, Хэнтий аймаг 104.8 хувийн хэрэгжилттэй байгаа.

Ганцхан аймаг 100 хувьд авсан. Энэ бол Увс аймаг. 108 хувийн хэрэгжилттэй байгаа буюу Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлсэн 21 аймгаас ганцхан аймаг байна гэсэн үг. Эдгээр мөнгийг саяын Сангийн яамны даргын хэлдгээр сум иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар өөрсдөө төсвөө бүрдүүлэх хэлбэр дээр ашиглаад явж байгаа. Эндээс нөгөө ойн хөнөөлт шавжийн мөнгө, нөгөө хөвд цөөрөм байгуулах мөнгө, нөгөө байгалийн ургамалтай холбоо бүхий асуудлуудыг шийдвэрлэх мөнгө, нөгөө байгаль орчинд ялангуяа байгалийн дагалдах баялаг ашигласны хүрээнд буцаагаад зарцуулах ёстой энэ мөнгөнүүдийг бол зарцуулах ёстой. Энийгээ бол хангалтгүй хэрэгжүүлж байгаа гэсэн үг.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой асуудал Ашигт малтмалын тухай хууль мөн бусад холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд бид нар бас нэлээн олон үйл ажиллагаа бол зохицолдолгоог нь харж хялбаршуулахаар ажиллаж байгаа тухайлах юм бол нэг гомдол байдаг.

Аймаг сумд нөхөн сэргээлтийн байршуулсан мөнгийг буцааж олгодоггүй. Танайх дахиад юм хийнэ биз дээ гэж шантаажилж аж ахуйн нэгжүүдээс тухайн мөнгийг нь авдаг гэдэг ийм гомдол бол Байгаль орчин, аялал, жуулчлалын яаман дээр ирдэг. Энэ утга агуулгын хүрээнд ер нь жишээлэх юм бол нарийвчилсан үнэлгээтэй цуг менежментийн төлөвлөгөөг 5 жилээр баталж байгаа.

Тэгэхээр бид нар нэгэнт баталсан 5 жилээр баталсан энэ менежментийн төлөвлөгөөг жил болгон дахин дахин баталж дуудаж аж ахуйн нэгжүүдийг зовоох хэрэг байгаа юу? Тухайн аймаг сумдуудад заавал бэлэн мөнгөөр мөнгө байршуулах хэрэг байгаа юу? Яагаад банкны баталгаа байж болохгүй вэ гэх мэтчилнээр тодорхой хэмжээнд Аж ахуйн нэгжүүдийг дэмжих эдийн засгийг босгох, шат дарааллыг бууруулах гэдэг хэлбэр дээр бол байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой асуудлууд дээр бол Байгаль орчны багц хуулиудын хэмжээнд бид нар тодорхой хэмжээний судалгааны ажлууд хийгдээд явж байгаа. Удахгүй та бүхэнд бас тодорхой хэмжээнд өргөн баригдахаар танилцуулагдах байх гэж бодож байна.

Ер нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар төвлөрч байгаа орлогыг Байгаль орчин уур амьсгалын санд төвлөрүүлэх ёстой юм байна лээ. Ингэж байж өнөөдөр Монгол Улс нэгдмэл нэгдсэн тогтолцоогоор явах боломж маань бүрдэнэ. Тэгэхгүй тохиолдолд өнөөдөр Байгаль орчин, аялал жуулчлалын яам төрийн захиргааны байгаль орчин

хариуцсан төв байгууллагын хувьд бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй хэлбэр дээр байгаа. Жил болгон ойн.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр 2024 онд бас 80-аас доошгүй хувь нь хэрэгжинэ гэж ойлгож байна. Тэгэхээр энэ дээр бас Сангийн яам Байгаль орчин, аялал жуулчлалын яам илүү их хамтарч ялангуяа энэ байгалийн нөөц ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр дээр тодорхой мөнгөнүүд орчихсон. Энийг нь яг тэр санд нь оруулаад усаа хэмнэх усаа дахин ашиглах болоод эд нар дээр нь ашиглаж авах дээр нь хамтарч ажиллахыг хүсэж байна. Тэгээд дахиад бас нэг төсөв хэлэлцэхэд энэ нь ийм бага хувьтай гэж ярихгүйгээр өнөөдрийн бас энэ хурлын үр дүн гарна гэж итгэж байна аа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Гишүүдэд зарчмын зөрүүтэй санал байвал өгөөд зарчмын зөрүүтэй саналаар санал хураана.

Надад нэг гишүүний санал ирсэн байна. Эхнийхээ саналыг та бүхэнд танилцуулъя. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Энийгээ дуусгаадахъя. Зарчмын зөрүүтэй санал руу орё.

2024 оны төсвийн тухай хуулийн 6.1.8-д заасны дагуу зарчмын зөрүүтэй санал оруулж ирж байгаа.

Эхний томъёолол бол Аялал жуулчлалын байгалийн түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол, бүхий отоглох цэг. Төсөвт өртөг нь 2 тэрбум 325 сая төгрөг байгаа.

Энэнээс 374.1 сая төгрөгөөр бууруулж аялал жуулчлалын байгалийн түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэгийг Булган аймаг Рашаант

сум Элсэн тасархайд төсөвт өртгийг санхүүжүүлэхээр саналыг Анандбазар гишүүн оруулсан байна.

Тэгээд төсөвт өртөг нь бол 374.1 сая төгрөг гэсэн байгаа. Тэгэхээр энийгээ бас яг Анандбазар гишүүн салбарын сайдтай зөвшилцөөд оруулж ирж байгаа. Тэгэхээр энэ дээр гишүүд дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Дахиад Ганболд гишүүн санал дэвшүүлъя гэж байна.

Г.Ганболд: Гол нь ингээд байна л даа та хэд маань нөгөө яг адилхан 2 төслийг нэг нь болохоор Увс аймаг гэж тавингуутаа 374.1 гэхээд дараагийн 2.3 нь болохоор зэрэг улсын хэмжээнд гэхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр Анандбазар бол ингээд Увс гэж яагаад заавал тэрнээс нь салгаж тавьчхаад яг адилхан нэр томъёоллоор дараагийн үлдсэнийг нь 2.3 гэхихсэн байна. Тийм учраас тэрэн шиг ингээд нэр зааж тавиулъя гэдгээр л зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа шүү дээ. Уучлаарай. Сая би нөгөө санал өгсөн чинь төхөөрөмж ажилласангүй.

Тийм учраас саяын саналыг хүчингүй болгох санал хураалт явуулж өгөөч.

Б.Саранчимэг: Ганболд гишүүний саналыг дэмжиж байгаа саналаар санал хураалт явуулъя. Саналыг хүчингүй болгох санал хураалт.

Санал хураалт.

Ганболд гишүүний санал дэмжигдэж түрүүний санал хураалт хүчингүй боллоо. Дахин санал хураалт явуулъя.

Анандбазар гишүүний саналаар санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн санал хураалт.

Санал тэнцээд энэ санал дэмжигдсэнгүй. Тэгэхдээ Төсвийн байнгын хороон дээр дахиад энийгээ танилцуулах боломжтой. Ажлын хэсэг дээр дахиж ярих боломжтой гэсэн үг.

Дараагийнхаа хэлэлцэх асуудал руу оръё. Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийсэн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батжаргал гишүүн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна аа.

17.58 цагт

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ганц асуудал. Сая төсвийн 2 дугаар хэлэлцүүлэгт оролцсон ажлын хэсгийнхэн та бүхэнд баярлалаа.

Хоёр дахь хэлэлцэх асуудалтай холбогдуулж ажлын хэсэг орж ирж байгаа. Та бүхэнд танилцуулъя.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга Баасандорж Баярбат Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга, Энхтуяа, мөн газрын хууль, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга, Дөлгөөнтүүл ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын референт.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Анхны хэлэлцүүлэг байгаа учраас зүйл бүрээр хэлэлцэх байгаа.

Та бүхэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцэнэ ээ.

Асуух асуулттай гишүүд байхгүй учраас дараагийнхаа асуудалд оръё. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд алга.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсэг өмнөх хэвээрээ байгаа. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Гишүүд алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна, санал гараагүй байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Геодези зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулья.

Ажлын хэсэг өмнөх хэвээрээ байгаа.

Тэгэхээр хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгье. Гишүүд байхгүй байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Зарчмын зөрүүтэй санал алга байна. Асуулт асуусан гишүүд гарсангүй.

Дараагийн хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрөөтэй санал ирүүлээгүй байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Геодези зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батжаргал танилцуулна аа.

Өнөөдөр Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанд идэвхтэй оролцсон эрхэм гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

18.04 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА